

“Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь”

“Бэлгийн мөлжлөг болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийг халамжлах нь” – Сургагчдад зориулсан тэмдэглэл.

Зорилго: Бэлгийн мөлжлөгт ашиглаж байсан хүүхдүүдийг халамжлагчдыг орон нутагт нь сургах сургалтыг зохион байгуулах сургагч нарт энэхүү гарын авлагыг зориулав.

Сэдэв бүрийг тусгай хэсгүүд болгон бэлдсэн учир, энэхүү гарын авлагыг хүүхдийн хүчирхийллийн эсрэг болон хүүхдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахын эсрэг өөр ямар нэгэн сургалт явуулах болон илтгэл тавихад ашиглаж болох юм.

Ашиглалт: Энэ гарын авлагыг оролцогчдын хэрэгцээ шаардлага болон тухайн улс орны нөхцөл байдалд тохирсон сургалтын материалыг боловсруулахад ашиглана. Энэ бол санал бодлын эх бөгөөд эцсийн, эсвэл зааварчилсан программ биш юм. Хичээлийн эхлэл болон төгсгөлийн дасгалуудыг энэхүү номд оруулаагүй хэдий ч, сургалтын явцад тэднийг зохих цаг үед нь оруулан хэрэглэхийг зөвлөж байна.

Сургалтын материалыг боловсруулахдаа:

- Оролцогчдын туршлага, чадвар ямар вэ?
- Оролцогчид ямар нэмэгдэл, онцлог мэдлэгийг авч ирэх вэ?
- Өгч буй материалд сэтгэхүй болон соёлын онцлог хэрхэн нөлөөлөх вэ?
- Өөр соёл, шашин шүтлэг бүхий хүмүүс аливаа зүйлийг хэрхэн өөрөөр хардаг вэ?
- Тэд ямар бодол санаатай байх вэ? гэх зэрэг асуудлуудыг анхаарвал зохино.

Зарим хэсгүүд нь тодорхой чадварт тулгуурласан болохыг харгалзан, хичээлийг ойлгомжтой болгоход туслуулахаар зохих мэргэжил бүхий хүнийг урьж оролцуулах нь зүйтэй байж болох юм.

Номд өгөгдсөн хугацаа болгон ойролцоогоор байгаа бөгөөд хэсгүүдийн үргэлжлэх хугацаа нь сургагчийн тогтоосон цаг болон дасгал хэлэлцүүлэгт зориулах цагаар тодорхойлогдох болно.

Бүрэлдэхүүн хэсэг

Хамарвал зохих үндсэн санаанууд, оролцогчдын мэдлэг, чадвараас хамаарсан илүү гүнзгий шатны бүлгүүд тус удирдамжид орсон болно. Бүлэг бүрт мэдээлэл, бүлгийн болон бие даасан дасгалуудыг оруулсан. Бүлгүүд нь хамтарсан, хамтын ажиллагаанд чиглэгдсэн бөгөөд оролцогчид болон удирдагчийн харилцан ярианд тулгуурлахаар хийгдсэн болно.

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 1

Бүтэц

Бүлэг бүр тухайн хэсгийн зорилгыг илтгэсэн хэсгийн төлөвлөгөө, шаардлагатай эх булгууд, хичээлийг удирдах заавар болон удирдагчийн тэмдэглэлийг агуулсан. Үүний дээр дугаарласан дасгалын хуудсуудыг мөн өгөгдсөн. Тэдгээр дасгалын хуудсуудыг хувиалан тараах эсвэл хэрвээ илтгэл тавихад хэрэглэх бол үзүүлэн, пауер пойнт юм уу флип картууд маягаар ашиглаж болно.

1. ХАМТДАА СУРЦГААЯ

Хичээлийн явцад бүлгээрээ хэрхэн хамтран ажиллах вэ?

Зорилго:	Энэ бүлгийн зорилго нь хүмүүст хамтран ажиллаж хамтран суралцах хүсэл эрмэлзлийг төрүүлэхүйц сургалтын орчинг бүрдүүлэх болон сургалтанд хамрагдагчид тухайн программд ямар зорилттой оролцож, юу сурахыг хүсэж байгааг тогтооход оршино.
Шаардлагатай материал:	Том цаас, үзэг, “жагсаалт”-ыг хананд тогтоох хэрэгсэл
Хугацаа:	30-60 мин

<p>Сургагчийн тэмдэглэл Хэрвээ шаардлагатай гэж үзвэл:</p> <ul style="list-style-type: none">✓ Цаг барих✓ Хувийн нууцыг хадгалах✓ Бусдын санал бодлыг хүндэтгэх✓ Сонсох✓ Хувийн шинж чанартай зүйл хэлэхгүй байх.✓ Сургалт бол нээлт байдаг учраас алдаа гаргахаас айж ичихгүй байх талаар урьдчилан ярилцах.	<ul style="list-style-type: none"><input type="checkbox"/> Бүлгийн хувьд сургалтын хугацаанд хамтран ажиллах үндэс болгон ашиглах “Дүрэм”-ийн жагсаалтын бүлгээрээ хэлэлцэн батлана.<input type="checkbox"/> Сурч мэдэхийг хүсэж буй зүйлсийн жагсаалтыг гаргасны дараа сургалтын хугацаанд авч үзэхгүй салбарыг мөн тогтоох нь чухал.
--	---

2. Орчин ба нөлөөлөл

Хүүхдүүд болон хүүхдийн хүчирхийллийн талаар бидний ойлголт хэрхэн төлөвшдөг вэ?

Зорилго:	Энэ бүлгийн зорилго нь хүүхдийг хүчирхийлэх гэдэг бол “тогтсон” ойлголт биш гэдгийг оролцогчдоор
-----------------	--

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 2

	хүлээн зөвшөөрүүлэхэд оршино. Оролцогчдын хувийн туршлага нь хүүхдүүдийн талаархи тэдний бодолд хэрхэн нөлөөлж байдаг талаар бодоход нь оролцогчдод мөн туслана.
Шаардлагатай материал:	Том цаас, үзэг, дэвтэр, w2.1 ба w2.2 дасгалын хуудсууд
Хугацаа:	30-60 мин

<p>Сургагчийн тэмдэглэл Асуулгын зорилт нь:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Оролцогчид яагаад ирсэн болон тэд сургалтаас юу сурж мэдэхийг хүсэж байгаа талаар хос хосоор хэлэлцэнэ. ✓ “Хамтрагч” бүр хэлэлцэж ярилцсан зүйлээ нийт бүлгийнхэндээ танилцуулан, удирдагч тэдний сурч мэдэхийг хүсэж зүйлсийн жагсаалтыг том цаасан дээр бичнэ. ✓ Жагсаалтаа сургалтын туршид харагдаж байхуйц газар өлгө. Хэрвээ оролцогчид хүсвэл сургалтын явцад нэмэлт хийж болно. 	<p>Сургалтын программыг гүйлгэн харж, хүлээж буй зүйлстэй хэрхэн тохирч байгааг тодорхойлно.</p>
---	--

<p>✓ Асуулгын зорилт нь маргааныг өдөөн сургалтанд оролцогчдын бодол санааг тодруулахад оршино.</p> <p>✓ Оролцогчдын хяналтгүй \инстинктив\ хариуг авахын тулд үүнийг аль болох хурдан хийх хэрэгтэй.</p> <p>✓ Хэрвээ хүн бүр санал нэгдэж байвал тэд яагаад бүгд адил саналтай байгаа талаар бүлэгтэйгээ ярилцана.</p> <p>✓ Өөрсдийгээ тодорхойлох 10 үгийг хуудас цаасан дээр бичихийг оролцогчдоос хүс. Дараа тэд хэрхэн өөрсдийгөө тодорхойлсныг болон яагаад тэд үүнийг ийм маягаар хийв гэдгийг нь, өөрөөр хөлбэл яагаад зарим нь биеийн байдлаа эхэлж бичиж, зарим нь бусадтай харьцах харьцаанаас эхэлсэн байхад нөгөө хэсэг нь хүйс, арьс өнгө, анги давхарга, шашин шүтлэгээсээ эхлэв гэдгийг бүлгээр хэлэлц.</p> <p>Бид ертөнцийг бусдаас өвөрмөцөөр хардаг гэдгийг хүлээн зөвшөөрөх нь бусад хүмүүс яагаад өөр бодол саналтай байгааг ойлгоход бидэнд туслахын зэрэгцээ бидний өөрсдийн үнэлгээ хаанаас гарал үүдэлтэй болох, хүүхэд хүчирхийлэх гэх мэт нөхцөл байдалд бидний өгөх хариунд энэ нь хэрхэн нөлөөлж байна гэдгийг эрэгцүүлэн бодоход бидэнд туслана.</p>	<ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> w2.1 дасгалын хуудсуудыг хүн бүрт өгч бөглүүл. Бөглөж дууссаны дараа нөхцөл бүрийг уншин, сонсогчдын саналыг ав. <input type="checkbox"/> Энэ ажлын зорилго, оролцогчдыг өөрсдийн хувь чанарыг хэрхэн бүтээсэн талаар нь зүгээр л бодуулахад оршино. Жишээлбэл, тэд өөрсдийгөө эх хүн гэж эхэлж бодож байна уу? Хар гэж эхэлж бодож байна уу? гэдгийг нь бодуулахад оршино. <input type="checkbox"/> Хэсгээр / 4-6 хүн / ажиллан, орчин бүрт тохирох 3 нөхцөлийг тодорхойл. <input type="checkbox"/> Өөрслийн бүлэгтээ танилцуул. <input type="checkbox"/> w2.2 дасгалын хуудсыг ашиглан бидний ертөнцийг хардаг “шил” хүн болгоны хувьд онцлог байдаг олон тооны линзүүдээс тогтдог болохыг тайлбарла.
--	--

<p>Жишээлбэл, “хуулийн орчин”-гэрлэх насыг хуулинд хэрхэн заасан байна?</p>	
---	--

<p>✓ Асуулгын зорилт нь маргааныг өдөөн сургалтанд оролцогчдын бодол санааг тодруулахад оршино.</p> <p>✓ Оролцогчдын хяналтгүй \инстиктив\ хариуг авахын тулд үүнийг аль болох хурдан хийх хэрэгтэй.</p> <p>✓ Хэрвээ хүн бүр санал нэгдэж байвал тэд яагаад бүгд адил саналтай байгаа талаар бүлэгтэйгээ ярилцана.</p> <p>✓ Өөрсдийгээ тодорхойлох 10 үгийг хуудас цаасан дээр бичихийг оролцогчдоос хүс. Дараа тэд хэрхэн өөрсдийгөө тодорхойлсныг болон яагаад тэд үүнийг ийм маягаар хийв гэдгийг нь, өөрөөр хөлбэл яагаад зарим нь биеийн байдлаа эхэлж бичиж, зарим нь бусадтай харьцах харьцаанаас эхэлсэн байхад нөгөө хэсэг нь хүйс, арьс өнгө, анги давхарга, шашин шүтлэгээсээ эхлэв гэдгийг бүлгээр хэлэлц.</p> <p>Бид ертөнцийг бусдаас өвөрмөцөөр хардаг гэдгийг хүлээн зөвшөөрөх нь бусад хүмүүс яагаад өөр бодол саналтай байгааг ойлгоход бидэнд</p>	<ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> w2.1 дасгалын хуудсуудыг хүн бүрт өгч бөглүүл. Бөглөж дууссаны дараа нөхцөл бүрийг уншин, сонсогчдын саналыг ав. <input type="checkbox"/> Энэ ажлын зорилго, оролцогчдыг өөрсдийн хувь чанарыг хэрхэн бүтээсэн талаар нь зүгээр л бодуулахад оршино. Жишээлбэл, тэд өөрсдийгөө эх хүн гэж эхэлж бодож байна уу? Хар гэж эхэлж бодож байна уу? гэдгийг нь бодуулахад оршино. <input type="checkbox"/> Хэсгээр / 4-6 хүн / ажиллан, орчин бүрт тохирох 3 нөхцөлийг тодорхойл. <input type="checkbox"/> Өөрсдийн бүлэгтээ танилцуул. <input type="checkbox"/> w2.2 дасгалын хуудсыг ашиглан бидний ертөнцийг хардаг “шил” хүн болгоны хувьд онцлог байдаг олон тооны линзүүдээс тогтдог болохыг тайлбарла.
--	--

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв
“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 5

<p>туслахын зэрэгцээ бидний өөрсдийн үнэлгээ хаанаас гарал үүдэлтэй болох, хүүхэд хүчирхийлэх гэх мэт нөхцөл байдалд бидний өгөх хариунд энэ нь хэрхэн нөлөөлж байна гэдгийг эрэгцүүлэн бодоход бидэнд туслана.</p> <p>Жишээлбэл, “хуулийн орчин”-гэрлэх насыг хуулинд хэрхэн заасан байна?</p>	
---	--

**Орчин ба нөлөөлөл: Хүүхдүүдийн тухай бодол, та зөвшөөрч байна уу?
Эсвэл үгүй юу?**

/Дасгалын хуудас w2.1/

- | | Тийм | Үгүй |
|--|--------------------------|--------------------------|
| 1. Өнөөгийн хүүхдүүд хэт эрхэлсэн бөгөөд, урьд цагт хэзээ ч ийм сайхан амьдрал байгаагүй. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 2. Хүүхдүүд харагдаж байх ёстой бөгөөд сонсогдож байх ёсгүй. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 3. Бэлгийн харилцаанд орох / гэр бүл болохыг зөвшөөрөх насны хязгаарыг багасгах хэрэгтэй. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 4. Алгадах нь хүүхдэд гэм болохгүй бөгөөд сайн шийтгэл болдог. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 5. Хүүхдийн санал бодол том хүнийхтэй нэгэн адил чухал. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 6. Хөвгүүдийн ажиллах нас охидынхоос урт, учир нь тэд гэр бүлээ тэжээх мөнгө олох хэрэгтэй болдог учир хөвгүүд охидоос илүү боловсрол эзэмших ёстой. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 7. Хүүхдүүд гэр бүлийнхээ асрамж, халамжид өсөж торних ёстой. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |

- | | | |
|--|--------------------------|--------------------------|
| 8. Хүчирхийллийн тухай хүүхэд хэзээ ч худлаа ярьдаггүй. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 9. Том хүний хэлснийг хүүхэд ямагт гүйцэтгэх ёстой. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 10. Сургуульд явах эсэхээ хүүхдүүд өөрсдөө шийдвэрлэх чадвартай байх ёстой. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 11. Хүүхдүүд гэр бүлийнхээ нуруунд ачаа болж байх ёсгүй бөгөөд аль болох хурдан өөрийгөө авч явах чадвартай болох ёстой. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 12. Эцэг эх нь ажилтай завгүй байхад хүүхдүүд дүү нараа харж байх ёстой. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 13. Ажил хийх дадлага чадварт суралцах нь сургуульд явахаас илүү чухал. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 14. Хүүхдүүдэд дэндүү эрт амьдралын хариуцлага ноогдуулж байна. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 15. Хүүхдүүдэд хангалттай хариуцлага ногдуулахгүй байна. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 16. “Юу ч байхгүй явах” нь хүүхдүүдэд юмны үнэ цэнийг ойлгуулна | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |

Юу бидэнд нөлөөлдөг болон бид ертөнцийг хэрхэн хардаг вэ? Дасгалын хуудас w2.2

Хүүхдүүдийг жишээ болгон үзэхүй

Хүүхдийн хувьд юу ердийн зүйл болох тухай бидний бодол санаанд олон хүчин зүйл нөлөөлөн, өөр өөрийн онцлог үзлийг бүрдүүлдэг:

- **Хуулийн орчин** – Хуульд юү гэж заасан байна / Жишээлбэл, зөвшөөрөх насны талаар/
- **Нийгмийн орчин** – Бидний амьдарч буй нийгэмд нийтлэг баримтлагдаж буй үзэл бодол ямар байна
- **Соёлын орчин** – Аливааг бидний соёлын үүднээс хэрхэн үзэж байна / Жишээ нь, эмэгтэй хүнийг эрчүүдийн нэгэн адил өндөрт үзэж байна уу/ - энд яс үндэс, хүйс гэх мэт асуудлууд хамаарна

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 7

- **Шашин мөргөлийн орчин** – Бидний сүсэг бишрэл, шашин юу гэж хэлж байна
- **Хувийн орчин** – Бидний өнгөрсөн туршлага бидэнд ертөнцийг хэрхэн үзэхийг сургасан болон бидний үзэл бодлыг хэрхэн төлөвшүүлсэн
- **Ёс суртхуун/ Мэргэжлийн орчин** – Бидний “мэргэжил” бидэнд юу хэлж байна / зарим орны мэргэжилтнүүдийн хувьд хүүхэд хүчирхийллийн тухай сэжиг бүхнийг илтгэх нь албан ёсны үүрэг нь байдаг/
- **Хүрээлэн буй орчин болон Эдийн засгийн орчин** – Амьд явахын тулд хүмүүс юу хийх хэрэгтэй вэ? / Хэрвээ ургац алдвал гэр бүлээ хэрхэн гэжээх вэ/
- **Зохион байгуулалтын орчин** – Байгууллагын соёл ямар байх вэ? / Хүүхдүүд анхдагч үйлчлүүлэгч үү, эхчүүд нь үү? Соёлын онцлогоос хамааран ямар нэгэн зүйл доромжлол байсан уу, үгүй юү гэдэг олон янзын санал бодол байж болно/

3а. Хүүхдийн бэлгийн хүчирхийлэл – (ХБХ) Энэ нь юу болох болон хэн өртөж болох вэ?

Зорилго:	Хүүхдийн бэлгийн хүчирхийлэл гэж юуг хэлэх талаар бодол санаагаа тодотгоход нь оролцогчдод туслах болон үүний тухай зарим буруу ташаа ойлголтыг залруулан засахад оршино.
Шаардлагатай материал:	Том цаас, үзэг, w3a.1 ба w3a.2 дасгалын хуудсуудын хуулбар
Хугацаа:	30-60 минут

Сургагчийн тэмдэглэл <input checked="" type="checkbox"/> Сэтгэл шаналам сэдвийн талаар үзэж байгаа учраас оролцогчид хичээлийн материалын улмаас тавгүй	Семинарын явц <input type="checkbox"/> Хүүхдийн бэлгийн хүчирхийлэл гэж юу болох болон түүнд ямар үйлдлүүд хамрагддаг талаар группээрээ хэлэлц.
---	---

байдалд орж магадгүй гэсэн сэтгэлзүйн бэлтгэлтэй байх хэрэгтэй.

- ✓ Хэрвээ ярилцахыг хүсвэл хүмүүс бодол санаагаа бүлгийхэнтэйгээ хуваалцаж болох юм – тэднийг битгий хүчил!
- ✓ Хэрвээ оролцогчид энэ бүх нөхцлийг хүүхдүүдэд тохирохгүй гэж хүлээн зөвшөөрч чадахгүй бол тэд ажлаа зөв сонгосон эсэхээ эргэн харах хэрэгтэй болно.

Хүүхдүүд бэлгийн дарамтлалд өртсөний үр дагаварт:

- Аймшиг
- Сэтгэлээр унах
- Өөртөө итгэлгүй байдал болон өөрийгөө дорд үнэлэх
- Нийгэмших чадвар муу байх
- Уур хилэнтэй бөгөөд аливаад дайсагнан хандах
- Хожмын амьдралдаа бусдад итгэн утга төгөлдөр харилцаа тогтоох чадваргүй болох
- үүрэг хариуцлага болон хэмжээ хязгаарын талаар балархай ойлголттой байх,
- Овогтой харагдах
- Бэлгийн дуршилтай болох
- Өөрийгөө гэм буруутай мэт санах
- Бусдаас ичиж эмээх
- Өөрийгөө бусдаас “өөр” хэмээн бодох
- Зожигрол, өөрийгөө гэмтээх (амиа хорлох хүртэл) хэргийн дараах стресс болон өөр бусад олон зүйл ордог.

□ ХБХ-ийн тодорхойлолт болон w3a.1 дасгал хуудсанд бэлгийн хүчирхийлэл хэмээн тодорхойлсон үйлдлүүдийг үз.

□ ХБХ болон өгөгдсөн материалын талаархи санаа бодлоо хосоороо ярилц.

□ w3a.2 дасгалын хуудсыг тарааж өг. Судалгааны материалуудыг 4-6 хүнтэй баг бүлгээрээ хэлэлц. Эцэст нь бүлэг доторхи санал зөрөлдөөнд анхаарлаа онцгой хандуул.

□ Хүүхэд бэлгийн дарамтад өртсөний дараах үр дагавар, нөлөөг бүлгээрээ хэлэлц.

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 9

--	--

Хүүхдийн бэлгийн хүчирхийлэл – (ХБХ)
Хүүхдийн бэлгийн хүчирхийлэл гэж юу вэ?
Дасгалын хуудас **w3a.1**

Хүүхдийн бэлгийн хүчирхийлэлд:

- а) Хүүхдийн итгэлийг хөсөрдүүлсэн, хүүхэд эсвэл залуу болон ахмад, том биетэй өөрөө нь илүү хүчтэй хүний хоорондын **хүчний тэнцвэргүй харьцааны явцад үүссэн дарамт.**
- б) Хүүхэд эсвэл залуу хүн болон ахмад, том биетэй, өөрөөс нь илүү хүчтэй хүний хоорондын бодит, санаархсан эсвэл заналхийлсэн **бэлгийн үйлдэл** ордог.

ХБХ нь:

- Бэлгийн харьцаа санал болгох
- Бэлгийн энхрийлэл
- Бэлэг эрхтнээ нүцгэлэн харуулах
- Насанд хүрэгч гар хангалга үйлдэхийг харуулах
- Амаар бэлгийн хавьтал үйлдэх
- Хуруу эсвэл эрхтэнээ үтрээнд эсвэл хошногонд оруулах
- Порнограф үзүүлэх эсвэл хүүхдийг порнографийн зорилгод ашиглах
- Хүүхэд, амьтантай бэлгийн харьцаанд орох
- Бэлгийн гаж зуршил
- Хүүхдийг бэлгийн мөлжлөгт өртүүлэх.

Хүүхдийн бэлгийн хүчирхийлэл – (ХБХ)
Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн үү эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлд ороод байна уу?
Дасгалын хуудас **w3a.2**

Жишээ 1: Эмма

Эмма 10 настай. Ээж, хойд эцэг болон 8 настай охин дүүтэйгээ амьдардаг. Ээж нь жил орчмын өмнө хойд аавтай нь гэрлэжээ. Эммагийн ээж нь ажилдаа явсан нэг өглөө түүний хойд эцэг нь Эммаг охин дүүгийнх нь хамт гаражид авч ороод тэдний өмнө гар хангалга хийжээ. Тэр тэдэнд огт хүрээгүй бөгөөд тэдэнд аймаар санагдахаасаа илүү сонирхолтой байжээ.

Жишээ 2: Том

Том 14 настай. Ээжтэйгээ амьдардаг. Түүний ах нь 21 настай бөгөөд найз нартайгаа хамт амьдардаг. Том биеэ даасан характертай, ахтайгаа харилцаа тун сайтай, түүнтэй хамт цагийг өнгөрөөх дуртай. Том ахындаа дандаа очдог байна. Тэд хөзөр тоглож, идэж уун, кино үзэж цагийг өнгөрөөдөг байжээ. Томын ах болон түүний найз нар нь заримдаа “зөвхөн насанд хүрэгчдэд зориулсан” кино авч хамт үздэг байна. Томын ах болон ахынх нь найз нар нь бэлгийн харилцаанд ордоггүй, бэлгийн харилцаанд орохыг ч түүнд санал болгодоггүй байжээ. Тэд Томыг найз нарынхаа нэг мэт ханддаг байв.

Жишээ 3: Апуерна

Апуерна 11 настай. Өнөр өтгөн гэр бүлд амьдардаг. Түүний нагац эгч нь нас бараад удаагүй байна. Тэр үед түүний нагац ах нь сэтгэлээр их унасан байв. Харин сүүлийн үед тэр илүү хөгжилтэй болж, чамаас болж сэтгэл санаа минь дээшилсэн гэж Апуернад хэлдэг байв. Тэр түүнд бэлэг, амттан авч өгдөг бөгөөд энэ тухай хэнд ч хэлж болохгүй гэж хэлдэг байжээ. Хэрвээ тэр хэн нэгэнд хэлэх юм бол тэр түүнд юм авч өгөхөө болино гэж тэр хэлдэг байв. Апуернад хайртай, нагацынх нь анхаарал халамж таалагддаг байна.

Жишээ 4: Тарик

Тарик 12 настай. Гэр бүлийнхээ хамт амьдардаг. Саяхнаас түүний аав нь түүнтэй бнлгийн харицаанд орох болсон байна. Тарикт энэ таалагддаггүй бөгөөд тэр үүнээсээ ичиж, эвгүйрдэг боловч аав нь энэ бол хэвийн зүйл, түүнийг хэрхэн эр хүн болоход сургаж байна гэж хэлдэг байна.

Жишээ 5: Аки

Аки 10 настай. Түүнийг харж ханддаг байсан эмээ нь 7 настай байхад нь бурхан болсноос хойш, гудамжинд ганцаараа амьдрах болсон байна. Тэр гутал өнгөлж, хаягдал металл цуглуулан тушааж мөнгө олдог. Нэг жилийн өмнө, нэгэн эр хэрвээ түүнтэй амаараа хавьтвал мөнгө өгье гэж санал болгожээ. Аки татгалзаагүй бөгөөд одоо заримдаа бусад эрчүүлтэй амаар хавьтан мөнгө олдог болжээ

Зб. Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүд– (БМӨХ)

Энэ нь юу болох, хэн өртөх эрсдэлтэй вэ?

Зорилго:	БМӨГХ (энэ нь юу болох болон хэн түүнд өртдөг вэ) талаар нэгдмэл ойлголттой болоход оршино.
Шаардлагатай материал:	Том цаас, үзэг, w3b.1 ба w3b.2 болон w3b.3 дасгалын хуудсуудын хуулбар

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 11

Хугацаа:	30 мин
-----------------	--------

<p>Сургагчийн тэмдэглэл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ НҮБ-ын Конвенцийн дагуу 18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэж үздэг. ✓ Жишээ бүрийг бүлгээр хэлэлцэхэд хангалттай цаг гаргаж өгөөд үзэл бодлын зөрөлдөөн гарна гэдэгт бэлэн бай. ✓ Шашин шүтлэг, нийгэм соёлын ялгаанд онцгой анхаарал хандуул. Бусад хүмүүс юмыг хэрхэн үзэх вэ? гэдгийг бодолц. ✓ Хүн болгоны санаа нэг байна уу эсвэл оролцогчдын өөрсдийн амьдралын туршлагаас хамааран өөр өөр бодол санаатай байна уу? Гарч буй санал бүрийг бүлгээрээ хэлэлц. ✓ БМӨА-ыг жишээнд бичихдээ хичнээн зөөлөн үг хэллэг хэрэглэсэн ч БМӨА нь хэзээд доромжлол байдаг. 	<p>Сургалтын явц:</p> <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> 4-6 хүнтэй группээр ажиллан “Хүүхдийг бэлгийн мөлжлөгт өртүүлэн ашиглах” гэсэн ойлголтын тодорхойлолтыг гарган том цаасан дээр бичнэ. Бүлэг бүр өөрийн тодорхойлолтыг бүлэгтээ танилцуулна. <input type="checkbox"/> Дасгалын хуудас w3b.1 БТӨртсөн тухай тодорхойлолт болон Хүүхдийн Эрхийн талаархи НҮБ-ын конвенцтэй бүлгээрээ танилцана. Хосоор ажиллах ажиллагааг зохион байгуул. <input type="checkbox"/> Дасгалын хуудас w3b.2 дахь жишээнүүд дээр бүлгээр ажилла <input type="checkbox"/> БМӨ эрсдэл, БМӨ болон ХБХ-ийн хоорондын ялгааны талаар дасгалын хуудас w3b.3 ба w3b.4 –ийг ашиглан ажилла.
---	--

Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүд– (БТӨХ)

Хүүхдийг бэлгийн харьцаанд оруулж ашиглах гэж юу вэ?

Дасгалын хуудас w3b.1

Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүд:

“Хүүхдийг бэлэн мөнгөөр эсвэл өөр ямар нэгэн хэлбэрээр ашиг олох зорилгоор бэлгийн харьцаанд оруулан ашиглах үйлдлийг ихэвчлэн хэн нэгэн зуучлагч (эцэг эх, гэр бүлийн гишүүн, зууч, багш нь г.м) зохион байгуулсан байдаг”

НҮБ-ын Хүүхдийн эрхийн Конвенци

“Дурьдсан Талууд бэлгийн доромжлол болон бэлгийн замаар ашиглах бүх хэлбэрээс хүүхдийг хамгаалах үүрэг хүлээнэ. Үүний тулд Дурьдсан Талууд:

- a) Хүүхдийг бэлгийн аливаа хууль бус харьцаанд орохыг шаардах, албадах
- b) Янхандалт эсвэл өөр бусад хууль бус бэлгийн үйлдэлд хүүхдийг ашиг олох зорилгоор ашиглах
- c) Хүүхдийг порнограф үйлдэл болон порнограф материалуудад ашиглан орлого олохоос урьдчилан сэргийлэх олон талын болон хоёр талын хамтарсан, мөн үндэсний бие даасан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх ёстой”

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 12

18 нас хүрээгүй хэн бүхнийг хүүхэд гэж НҮБ үздэг.

Ажиллагаа: Хосоор ажиллан доорхи үгсийн тодорхойлолтыг бичээд өөрийн орон нутгийн хэлээр орчуул.

1. **Inducement**
2. **Coercion**
3. **Pornographic**
4. **Prostitution**

**Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүд - (БМӨХ)
Хүүхэд бэлгийн мөлжлөгт өртсөн үү? эсвэл өртөх гэж байна уу?
Дасгалын хуудас w3b.2**

Жишээ 1: Амбиа

Амбиа 15 настай. Түүний гэр бүл нь ядуу болохоор түрээсийн газартаа тариалсан жаахан юмаа борлуулан амьдардаг. Амбиа 2 эгч, 2 эрэгтэй дүүтэй. Эгч нарынх нь хуримын зардлыг төлөх, бас ургац алдсаны улмаас амь зуух хоол хүнсээ авахын тулд нутгийн мөнгө хүүлэгчээс зээлдсэн их өртэй. Хэрвээ Амбиа түүнтэй гэрлэвэл бүх өрийг нь хүчингүй болгох санал тавьсан байна.

Жишээ 2: Мартин

Мартин 13 настай. Эцгээс нь салсныхаа дараа эх нь дахин гэрлэх болсонд тэр дургүй байсан болохоор хойд эцэгтэй дургүй, гэр орондоо байнгын хэрүүл маргаантай байв. Нэгэн өдөр, ээлжит хэрүүлийн дараа тэр гэрээсээ оргон хот орох галт тэргэнд суув. Хотод ирээд хаашаа явах, юу хийхээ мэдэхгүй байлаа. Буудал дээр тэр нэгэн нөхөрсөг хүнтэй тааралдав. Тэр хүн түүнд, хэрвээ Мартин “түүийг харж хандахад тусалбал” тэр түүнийг хоол хүнс, орон байр, хувцас хунараар хангана гэж хэлжээ.

Жишээ 3: Марлин

Марлин 17 настай. Ээжтэйгээ амьдардаг. Түүнийг хүүхэд байхад нь эцэг нь хаяж явсан юм. Марлин кино од болохыг хүсдэг байв. Нэг удаагийн үдэшлэг дээр түүнтэй тааралдсан нэгэн эрийн тавьсан саналын урхинд орсон юм. Тэр эр түүнд “Насанд хүрэгчдийн кино” гэж нэрлэдэг кино хийдэг, харин Марлинд маш их чадвар байгаа бөгөөд тэр их мөнгө олж чадна гэж хэлсэн байна.

Жишээ 4: Камал

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв
“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 13

Камал 11 настай. Түүний эцэг нь нэгэн бизнесменийг гэртээ авчраад, Камалыг тэр эрийн хүслийг ханга гэжээ. Гэр бүлийнх нь үйлдвэрт ашигтай захиалгыг тэр бизнесмен өгнө гэж Камалийн эцэг найдаж байна.

Жишээ 5: Вера

Вера 13 настай. Түүнд гэрийнх нь ойрхон гэрийн үйлчлэгчийн ажил олсондоо түүний эцэг эх нь баяртай байлаа. Учир нь энэ бол тэр гэр орныхоо орлогод нэмэр болно гэсэн үг байв. Эхэндээ Верад ажил нь ч таалагдаж, хамт амьдрах болсон гэр бүлийнхэн ч таалагдаж байв. Гэтэл саяхан гэрийн эзэн, Вераг хүүд нь таалагдсан учир хүүтэйгээ бэлгийн харьцаанд орохыг түүнд санал болгожээ. Хэрвээ татгалзвал түүнийг хална гэж эзэн нь хэлээгүй ч, хэрвээ тэр зөвшөөрөхгүй бол түүнийг гэр рүү нь явуулна гэдэгт Вера итгэлтэй байгаа.

Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүд Хэн бэлгийн мөлжлөгт өртөх магадлалтай вэ? Дасгалын хуудас w3b.3

Ямар ч хүүхэд бэлгийн мөлжлөгт өртөх магадлалтай боловч,

- Эмсийн хүрээлэнд амьдардаг хүүхдүүд. Жишээлбэл, улаан дэнлүүний хорооллууд г.м
- Эцэг эхийнхээ аль нэгэнтэй эсвэл ямар нэгэн ахмад насны хамаатантайгаа ядуусын хороололд амьдардаг.
- Хар тамхи, архинд донтогчдын орчинд амьдардаг.
- Эрчүүд олноор цугладаг газрын ойролцоо амьдардаг. Жишээлбэл: Хуаран, ачааны тэрэгний зогсоол г.м
- Гудамж, галт тэрэгний буудал эсвэл орхигдсон байшинд амьдардаг
- Гудамжинд ажилладаг. Жишээлбэл: Гуйлгачин, гутал өнгөлөгч г.м
- Үйлдвэрт ажилладаг (үйлчлүүлэгчдэд үйлчлэхийг тэднээс шаардаж болзошгүй)
- Зэвсэгт мөргөлдөөний бүсэд амьдардаг
- Шашин шүтлэг, нийгмийн үзлийн үүднээс биеэ үнэлэхийг зөвшөөрдөг орчинд (бурханд зориулагдсан учраас ямар нэгэн гэгээнтэн эсвэл итгэн бишрэгчтэй бэлгийн харьцаанд орохыг хүлээн зөвшөөрдөг г.м)
- Хүнд нөхцөлд амьдардаг хүүхдүүд үүнд өртөх магадлал илүүтэй байдаг.

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 14

Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүд
Хүүхдийн бэлгийн хүчирхийлэл болон хүүхдийг бэлгийн мөлжлөгт
өртүүлэх хоёрын хоорондын ялгаа
 Дасгалын хуудас w3b.4

Хүүхдийн бэлгийн хүчирхийлэл	Хүүхдийг бэлгийн мөлжлөгт өртүүлэх.
Хүүхэд өөрийгөө хүч чадал багатай гэж боддог	Хүүхэд өөрийгөө хүч чадалтай гэж боддог
Хүүхэд уруу татагч байдаггүй	Хүүхэд уруу татагч байж болзошгүй
Ихэвчлэн гутрангуй, дуу яриа багатай байх боловч заримдаа түрэмгий, дуу чангатай мөн өөрийгөө хорлох хандлагатай байдаг (хар тамхи г.м)	ХБХ-ийн талаар эмоцоо (гэхдээ мэдрэмжээ биш)
“Дотоод систем”-ихэвчлэн сургууль, клубэд явсаар байдаг	“Гадаад систем”-сургуульд явахгүй байх г.м
Найз нөхөд, танилуудаасаа юмаа нуудаг	Найз нөхөд, танилуудтайгаа илэн далангүй
Хүчирхийлэгчээс бусад хүмүүс энэ бол муу юм гэж хэлдэг	Хүүхдийн амьдарч буй нийгмийн хүрээллийнхэн нь энэ бол сайн юм гэж хэлдэг байж болох юм
Хүмүүс нийтдээ өрөвдөж, дэмжиж ханддаг	Хүмүүс ерөнхийдээ үйлдэлийг нь сөргөөр үзэж ханддаг

**4. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн “онцлог ба хэрэгцээ”:
 Эдгээр хүүхдүүдийг асарч халамжлах нь ямар ялгаатай вэ?**

Зорилго:	Оролцогчид хүүхэд асрах талаар тодорхой ойлголттой, туршлагатай байх ёстой учраас сайн асрагч байх гэж юу болохыг сайн ойлгож байх ёстой. Энэ сэдвийн зорилго нь тэдний мэддэг
----------	--

	зүйлийг эргүүлэн сануулж, тэдний мэдлэгийг бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн онцлог ба хэрэгцээг ойлгох суурь болгон ашиглахад оршино.
Ашиглах материал:	Үзэг, том цаас, дасгалын хуудас w4.1, w4.2
Хугацаа:	60 минут

Сургагчийн тэмдэглэл	Сургалтын явц
<ul style="list-style-type: none"> ✓ Сургалтын явцын туршид орлоогчдын мэдлэг чадварт түшиглэ ✓ Тодорхойлсон хэрэгцээнүүд нь хайр, орон байр, халуун дулаан сэтгэл, дасгал сургуулилт, унтах, боловсрол, урамшуулал, зохицол, хил хязгаар гэх мэтийг хамарч байх хэрэгтэй. ✓ Энэ ажилд цаг их гарга. Орлоогчдыг өөрсдийн мэдлэгээ ашиглахад өдөөн дэмж. ✓ Эдгээр нь нийтлэг шаблон нөхцөлүүд бөгөөд хүүхэд бүрийн тохиолдол өвөрмөц гэдгийг санаж хүүхдийн хувийн нөхцөл байдлыг тооцож байх нь чухал болохыг орлоогчдод онцлон анхааруул! 	<ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> “Хүүхэд бүрт юу хэрэгтэй вэ” гэдгийг нийт бүлгээрээ хэлэлц. <input type="checkbox"/> Дараахь гурван асуудлыг хэсэг бүлгээр (4-6) хэлэлц: <ol style="list-style-type: none"> 1. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн онцлог хэрэгцээ юу вэ? 2. Ийм хүүхдүүдийг асарч халамжлахад ямар асуудал үүсч болох вэ? 3. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн асрагч нь ямар шаардлагуудыг хангасан байх ёстой вэ? <input type="checkbox"/> Нийт бүлэгтээ танилцуул. <input type="checkbox"/> Дасгалын хуудас w4.1 –ийг асрагчийн хувьд ямар “гомдолтой” тулгарч байсан талаараа бодно уу гэж хүс. <input type="checkbox"/> Дасгалын хуудас w4.2 –той нийт бүлгээрээ танилц.

**Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн онцлог ба хэрэгцээ
Хүүхдүүдийн тавьдаг нийтлэг “Гомдол” заавал бэлгийн хүчирхийлэлд
өртсөн буюу бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдтэй холбоотой байх
албагүй**

Дасгалын хуудас w4.1

Та харьцаж байсан хүүхдийнхээ тухай бод (заавал БМӨ хүүхэд байх албагүй). Тэдний гаргаж байсан “гомдлыг” тэмдэглэ.

ГОМДОЛ

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 16

- Амьсгалын замын асуудал
- Толгой өвдөх
- Ядрах- нойрны асуудал
- Буруу хооллолт ба ядаргаа
- Гэмтэл\ хуучин гэмтлийн нөлөө
- ХДХВ/ ДОХ болон бусад БЗХӨ
- Жирэмслэлт / зулбалт
- Архи, хар тамхи болон бусад зуршил
- Өөрийгөө хүндлэх хүндлэл болон өөрийгөө үнэлэх үнэлэмж бага
- Өөртөө итгэх итгэл буурсан
- Өөрийгөө үзэн ядах/ уур бухимдал/зэвүүцэл
- Өөрийгөө бусдаас өөр мэт санах\ гадуурхагдаж буй мэт санах
- Уналтад орсон мэт санах
- Ирээдүй ямар ч найдвар байхгүй мэт санах/ сэтгэл санааны дарамттай
- Насанд хүрэгчдэд итгэх итгэлээ алдах
- Бусад нь түүнийг “өдөөд байгаа” мэт санах, бусдыг дээрэлхэх хандлагатай
- Анхаарал төвлөрдөггүй
- Зохион байгуулалттай байх чадвар хязгаарлагдмал
- Цагийн мэдрэмж муу
- Үргэлж буруутай мэт өөрийгөө санах/ өөрийгөө буруутгах хандлагатай
- Түрэмгий
- Хувирамтгай
- Өөрийгөө гэмтээх санаатай/ эсвэл эрсдэлтэй алхам хийх дуртай байх

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 17

- Амиа хорлох оролдлого
- Хөгжлийн удаашралтай/ ойлголт муудах
- Хайр халамж болон бэлгийн хавьтлыг хольж хутгах
- Харилцаагаа удаан хадгалах чадваргүй
- Сахилгагүй
- Ялгавартай харьцаж чаддаггүй (“буруу” хүмүүстэй нийлдэг)
- Аальгүй, өдөмтгий
- Өөрийгөө “бараа таваар” мэт үздэг
- Сексийн мэдрэмж өндөртэй
- Хулгай хийдэг/ юмаа нуудаг
- Бусдыг дээрэлхэж, доромжилдог
- Оргодог
- Өөрийгөө эрх мэдэлгүй мэт санадаг, өөрийн санаснаар “эрх мэдэлд хүрэхийг” хичээдэг

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн онцлог хэрэгцээ

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийг асарч халамжлахад тохиолдож болзошгүй бэрхшээлүүд
 Дасгалын хуудас **w4.2**

❖ **Эрүүл мэндийн хувьд:**

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн эсвэл ашиглагдсан хүүхдүүд эрүүл мэндийн хувьд тааруу байдаг. БЗДХ-ын эрсдэл, хүчирхийллийн явцад эсвэл түүний нөлөөгөөр олсон гэмтэл, тамхи татсаны улмаас олсон агаарын дуслын замын өвчин болон амьдралынх нь хэв маягаас болж тусдаг бусад өвчинд өртөмтгий байдаг.

❖ **Нийгмийн болон Сэтгэл зүйн хувьд:**

“Бэлгийн хүчирхийллийн динамик”

▪ Аальгүйтэх

Хүчирхийллийн явцад хүүхдийн бэлгийн дуршил буруу хөгжих нь байдаг. Үүний үр дүнд хүүхэд биеэ авч явах байдал болон бэлгийн харьцааны ёс суртхууны талаар буруу ойлголттой болох тохиолдол бий. Аальгүйтсэнийхээ төлөө шагнагдаж байсан учраас хүүхэд биеэ авч явах иймэрхүү хэв маягийг бусдыг удирдаж, санасандаа хүрч байх арга зам болгон ашиглаж сурдаг. Мөн биеэ авч явах байдлын талаар буруу ойлголттой болсны улмаас хүүхэд эрсдэлтэй нөхцөл байдлыг танин мэдэж чадалгүй өөрийгөө аюулд оруулж болзошгүй.

▪ Гутаан доромжлогдох

Тэдний өнгөрсөн амьдралын талаар сөрөг илгээмжүүдийг хүүхдүүд шууд ба шууд бус замаар олонтоо авдаг. Тэдгээр нь хүүхдүүдийн өөрсдийнхөө талаар бодох бодол санаа болон үнэ цэнээ мэдрэх мэдрэмжид засаж болшгүй нөлөө үзүүлж, тэднийг өөрсдийгөө буруутгахад хүргэдэг. Хүүхэд өөрийгөө хэрэггүй, чухал биш гэж боддог учраас энэ байдлаасаа “зугтахын” тулд архи, хар тамхи хэрэглэх гэх мэт эрсдэл, аюултай зүйлд хүргэж болох юм.

▪ Харьцааны хүндрэл

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд ихэвчлэн насанд хүрэгчдэд итгэх итгэлээ алддаг. Урьд нь өөрт нь тохиолдсон зүйлс дээр тулгуурлан, харилцаагаа үүсгэж хөгжүүлдэг. Тиймээс бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдэд бусад насанд хүрэгчдэд итгэх хэцүү байдаг.

Өөрсдийнхээ тухай бидний бодлын нэг хэсэг нь бусадтай харьцах харьцааны мөн чанарт үндэслэдэг. Тиймээс хэрвээ хүүхэд, итгэсэн насанд хүрэгчээсээ хайр халамж хүртэхгүй бол “Надад хэн ч хайргүй” ойлголт тогтоход хүргэдэг. Энэ нь хүүхэд насанд нь төдийгүй насанд хүрсэн хойно нь ч амьдралынх нь хэв маягт нөлөөлдөг.

▪ **Хяналт:**

Бэлгийн хүчирхийллийн үр дагавар нь хүүхдийн хүсэл санаа, бодол, бие даасан байдал нь өөрөөс нь илүү хүчтэй насанд хүрэгчийн “давамгайлагч” хүсэл бодолд тохируулан өөрчлөгдсөнд оршдог. Чадал муутай болохоо мэдрэх мэдрэмж нь амархан эмзэглэдэг болгох бөгөөд үр дүн нь хүүхдийг өөрийгөө хүч чадалтай, эрх мэдэлтэй гэдгээ мэдэрч чадах газрыг хайхад, эсвэл ямар ч нөхцөл байдалд эрх мэдэлд хүрч хяналтаа тогтоохыг оролдоход хүргэж болно.

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийн асран халамжлагчид юу хийх чадвартай байх ёстой вэ?

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийн асран халамжлагчдад хангалттай сайн асран халамжлагч байхад шаардлагатай, “ердийн” чадварын зэрэгцээ дараах чанарууд хэрэгтэй болно:

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 19

- **Бие махбодын аюулгүй байдлыг хангах**, жишээлбэл, өөрсдийгөө эрсдэлтэй байдалд оруулахаас хамгаалах, биеэ авч явах, өдсөн байдлыг аргацаахыг мэдэх болон болохгүй зүйлс хэрэглэдэг хүүхдүүдтэй ажиллаж чаддаг байх.

Мөн бие махбодын аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоор

- **Сэтгэл хөдлөлийн аюулгүй байдлыг хангах** Насанд хүрэгчид болон өөрсдийнхөө тухай бодлоо өөрчилж эхлэх, насанд хүрэгчидтэй зохих ёсны харьцаанд орсноор өөрийн боломжийг мэдрэн, сэтгэл зүйн хувьд эдгэх боломжийг хангахуйц орчныг бүрдүүлэх шаардлагатай. Үүнд хүрэхийн тулд асран халамжлагчид нь итгэл хүлээхуйц, нийцтэй, үгэнд ордог, найдвартай бөгөөд тэвчээртэй байх ёстой.

Үүний зэрэгцээ асран халамжлагчид:

- Багш, гэр бүлийн гишүүд гэх мэт хүүхдийн амьдралд чухал хүмүүстэй болон бусад мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж чадах
- Шаардлагатай үед дагаж дуурайх загвар болох
- Хүүхдүүдийн хүч чадлыг танин мэдэж хөгжүүлэх
- Зохих ёсны нийгмийн болон тусалж дэмжих сүлжээг бий болгоход нь хүүхдэд туслах
- Насанд хүрсэн хойноо бие даан амьдрах “амьдрах ухаанд” сургах чадвартай байх хэрэгтэй.

5. Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийн (БМӨХ) онцлог хэрэгцээ

Зорилго:	Энэ хичээл нь бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийн онцлог хэрэгцээг ойлгох асран халамжлагчдын ойлголт болон мэдлэгийг гүнзгийрүүлэхэд зориулагдсан бөгөөд сэтгэл зүйн хувьд анагаах үйлчилгээг хүргэх арга замыг хайхад чиглэнэ.
Ашиглах материал:	Үзэг, том цаас, дасгалын хуудас w5.1-w5.6
Хугацаа:	60 мин

Сургагчийн тэмдэглэл <input checked="" type="checkbox"/> Энэ бие халаалтын дасгал нь оролцогчдыг худал хэлэх болон	Сургалтын явц <input type="checkbox"/> Хэсэг бүлгээрээ- бүлгийн гишүүн бүр өөрийнхөө тухай нэг үнэн, нэг
--	--

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 20

<p>үнэнийг хүлээхээс татгалзахын хоорондын ялгааны талаар бодоход нь туслана. Худлаа хэлэхдээ тэд юу мэдэрч байсан бэ? Тэднийг амархан худлаа хэлэхэд нь юу тусалсан бэ? гэдгийг авч үз</p> <p>✓ Энэ бол ерөнхий үзүүлэлтүүд бөгөөд хүүхдүүд хоорондоо ялгаатай байдаг гэдгийг сануул.</p> <p>✓ Тэмдэглэсэн хүчин зүйлсийн утгыг тайлбарла. Энэ бол “Ерөнхийд” нь хүүхэд гэдгийг тодотгон зааж, эдгээр нь аливаа хүүхдийг тодорхойлох үзүүлэлтүүд болно гэсэн дүгнэлтэд хүрч болохгүй гэдгийг сануулах хэрэгтэй.</p> <p>✓ Өөр, өөр үзэл бодолтой тулгарахад бэлэн бай!</p> <p>✓ Үйлчилгээнүүд хэр үр дүнтэй болох, хүүхдийг бэлгийн мөлжлөгт өртүүлэх нь өөр ямар нэгэн орлуулах бодлогогүйгээр түүнийг зогсоохыг оролдох нь “зөв” эсэхийг, өөрөөр хэлбэл хүүхдийг бэлгийн харьцаанд оруулан ашиглахыг өөр ямар нэгэн орлуулах ямар бодит боломж байж болохыг авч үз.</p>	<p>худлаа зүйлийг хэлнэ. Бусад гишүүд нь асуулт тавьж аль нь худлаа болохыг олно. Нийт бүлэгтээ танилцуулна.</p> <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүд хэрхэн өөрсдийгөө хамгаалж, зууцалдаг вэ? гэдгийг бүлгээрээ хэлэлц. <input type="checkbox"/> Дасгалын хуудас w5.1 –ийг тараан өгч бүлгийн дэвшүүлсэн санаануудтай харьцуул. <input type="checkbox"/> Хэсэг бүлгээрээ БМӨХүүхдийн нийтлэг дүр төрхийг гарга. Нийт бүлэгтээ танилцуул. <input type="checkbox"/> Ажлын хуудас w5.2 ба w5.3 –ыг нийт бүлгээрээ үз. <input type="checkbox"/> Дасгалын хуудас w5.4 –ийг нийт бүлгээрээ үзэж БМӨХүүхдүүдтэй холбоотой дарамтыг хар. <input type="checkbox"/> “Бид хаана эдгээр хүүхдүүдтэй ажиллаж болох вэ?” гэдгийг нийт бүлгээрээ хэлэлц. Самбар дээр “Гудамж /Асрамжийн газар/ Халамжийн Төв” гэж бичээд эдгээр нөхцөлүүд ямархуу байж болохыг хэлэлц <input type="checkbox"/> Дасгалын хуудас w5.5 –ыг тарааж өгөөд энд заасан аль нөхцөлүүд дасгалын хуудас w5.3-т тодорхойлсон ямар бүлгийн хүүхдүүдэд илүү тохирохыг хэлэлц. <input type="checkbox"/> БМӨХүүхдүүд нийгмийн сэтгэл зүйд дахин зохицоход нь туслахын тулд БМӨХүүхдүүдэд ямар үйлчилгээ хэрэгтэй байж болох талаар жагсаалтыг хэсэг бүлгээр (4-6) хэлэлцэн гарга. <input type="checkbox"/> Нийт бүлэгтээ танилцуул. <input type="checkbox"/> Дасгалын хуудас w5.6-г тараан өгч шаардлагатай үйлчилгээнүүдийн талаар ярилц.
---	--

Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийн (БМӨХ) онцлог хэрэгцээ

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага. [Type text] 21

Хандлага ба өнгөлөн далдлалт

Дасгалын хуудас w5.1

□ БМӨХүүхдүүдэд хандах хандлагын нийтлэг ялгаа

Охидууд		Хөвгүүд	
Айдас	Жирэмслэлт	Айдас	Ижил хүйстэнтэйгээ хавьтагч байх / болох
Мэдрэмж	“Өөрөө биш мэт санагдах” Бусад хүмүүс тэднийг жигшиж байгаа мэт санагдах, Буруушаах Нэр хүнд\ байр суурь нь унасан мэт санагдах.	Мэдрэмж	Ижил хүйстэнтэйгээ хавьтагчтай явсанаас педофил(бага насны хүүхэдтэй явалдагч)-тэй явсан нь дээр Хэрвээ ядуу бол Биеэ үнэлэхийг боломжын зүйл гэж үзэх
ОДОО	Биеэ үнэлэхийг “зүгээр л ажил” гэж үзэх Мөнгөний хэрэгцээ/ хүсэл Ганцаараа байх дургүй	ОДОО	Биеэ үнэлэхийг “зүгээр л ажил” гэж үзэх Мөнгөний хэрэгцээ/ хүсэл Ганцаараа байх дургүй Ажилдаа дуртай/ ажлаасаа таашаал авдаг
	“Жинхэнэ дурлал” болон удаан хугацааны харилцааны тухай мөрөөдөх (“Аврагдах”)		Гарахыг хүсэх

□ Өнгөлөн далдлах нийтлэг хэлбэрүүд

1. Донтох
2. Материаллаг/ хэрэглэгчийн хандлага эсвэл “өөрийгөө зөвтгөх” (хувцас, хоол г.м)
3. Рационализм (“бид мэргэжилтнүүд”)

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 22

4. Өөрийгөө хангадагаараа бахархах
5. Ой санамжийн түр зуурын муудалт (“мартамхай”)
6. Ялгарах (өөрөөр хэлбэл өөрийгөө тухайн нөхцөл байдлаас тусгаарлах)\ үгүйсгэх
7. Нууцлаг/ нэрээ нуух
8. Стоицизм (ашиг олох зорилгоор бэлгийн харьцаанд орох нь ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй гэж үзэж буй мэт байх)

□ **Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийн (БМӨХ) онцлог хэрэгцээ**

Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн “нийтлэг” төрх

Дасгалын хуудас **w5.2**

1. Охид – ихэвчлэн “өмч” мэт үзэгддэг
2. Өмнөх хүчирхийллийн дурсамж
3. Сурч боловсрох боломж бага / байхгүй
4. Соёлын орчны таагүй байдал. Жишээлбэл, хүүхдийн гэрлэлт, онгон г.м
5. Тогтвортой бус гэр бүлийн орчин (гэр бүл салалт г.м)
6. Асрамжид байдаг
7. “Хэрэглэгчийн сэтгэхүйн золиос” тансаг хэрэглээний төлөө мөнгө хүссэн
8. Хуулийн муу орчин – хүүхэд гэмт хэрэгтэн мэт үзэгддэг эсвэл хүүхэд хамгааллын хууль нь хэрэгждэггүй

9. Авилгад автсан засаг захиргаатай – нийгмийн эмзэг бүлгийн гишүүдийг хамгаалах улс төрийн эрмэлзэл байхгүй

10. Цөөнхийн бүлгийн гишүүн

11. Бараа таваар мэт үзэгддэг. Жишээлбэл, хувь хүн биш харин бэлгийн хүсэл хангагч мэт үзэгддэг.

Бэлгийн мөлжлөгт өртөсөн хүүхдүүдийн (БМӨХ) онцлог хэрэгцээ Бэлгийн мөлжлөгт өртөсөн хүүхдүүдийн “бүлэгчлэл”

Дасгалын хуудас **w5.3**

• **Бэлгийн мөлжлөгт орсон хүүхдүүдийн “бүлэгчлэл”**

Тохиолдлын	Хяналтанд	Боолчлогдсон
Хэдийгээр чөлөөтэй боловч санхүүгийн хамааралтай байж болох – эхлэх сонголт хийх боломжтой \ үйл ажиллагааг зохицуулах зарим боломжууд бий. “Зуршил” болж болзошгүй Мөнгөтэй байх нь хүүхдэд бие даасан байдлыг мэдрүүлсэн бийлэг / тогтвортой гэр бүлээс байж болно.	Үйлдийн хязгаарлагдмал хяналт “Зууч” оролцсон Уруу татагдсан, албадуулсан эсвэл хулгайлагдсанаар аливаа зүйл эхэлсэн “Зуршил” болох нь их байдаг	Хяналтгүй “Боолчлогдсон” Тамлалттай адилтгаж болох зовоолт

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртөсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага. [Type text] 24

--	--	--

Та ажлынхаа хүрээнд таааралдаж байсан хүүхдүүдээ сана – аль категори тэдэнд илүү тохирч байна?

**Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийн (БМӨХ) онцлог хэрэгцээ
Бэлгийн мөлжлөгтэй холбоотой дарамтууд**

Дасгалын хуудас **w5.4**

1. Бэлгийн хүчирхийллийн шийдэгдээгүй асуудлууд (Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийн 75 % нь урьд нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн байдаг)
2. Хүүхэд байх үеийн “ердийн” дарамт
3. Мөнгө олох шаардлага (зууч, гэр бүл эсвэл өөрийнхөө хэрэгцээг хангахын тулд)
4. Үүний үр дүнд бие бялдарын болон эрүүл мэндийн асуудал (ХДХВ г.м)
5. Хар тамхи, архи болон бусад зүйлс хэрэглэх
6. Насанд хүрээд хууль ёсны ажил алба хаших боломж бага / байхгүй

Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийн (БМӨХ) онцлог хэрэгцээ
Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдтэй ажиллах нийтлэг гурван хэлбэр – арга зүй ба нийтлэг шинж чанарууд

Дасгалын хуудас **w5.5**

Гудамж / Хөдөлгөөнт	Халамжийн Төв	Асрамжийн газар
Орчинд нь бага багаар оруулах	Залууст хэт их шаардлага	Илүү зохион байгуулалттай, илүү

<p>(бэлгэвч, тариураар хангах г.м) болон эрүүл мэндийн шинжилгээ санал болгох замаар эрсдэл багатайгаар биеэ авч явахад уриалах болон эмнэлгийн шинжилгээ санал болгоход илүү чиглэж ажилладаг</p> <p>Биеэ ийнхүү авч явахыг нь зөвшөөрч байна гэж олон нийт, улс төрчдийн зүгээс заримдаа шүүмжлүүлдэг</p>	<p>тавихгүйгээр дэмжлэг үзүүлдэг – биеэ үнэлэх амьдралыг орхих гүүр нь болох боломжтой</p> <p>Ийм төвүүдэд үзүүлж буй дэмжлэгийн албан ёсны бус байдал нь хүүхэд залууст завсарлага авахад нь туслан тэдэнд маш ашигтай боловч тэднийг үйлчилгээтэй холбогдхогүйгээр зөвхөн ханган нийлүүлэгчдийн хооронд үсчин явахад хүргэж болдог (гэрээ болон нэгдсэн бүртгэл үүнийг багасгахад тусалж магадгүй)</p>	<p>албан ёсны тогтмол дэмжлэг, аюулгүй газраар хүүхэд залуусыг хангадаг. Гэр бүлтэйгээ дахин нэгдэх гүүр нь болох боломжтой (хэрвээ тохирох бол)</p> <p>Эхэндээ асрах газар дахь амьдралд дасан зохицох нь хүүхдүүдэд даван гарахад хэцүү мэт байж болох бөгөөд үүний үр дүнд биеэ явах байдалд нь асуудал үүсэж болох юм (уур хилэн, хүч хэрэглэх г.м)</p>
---	--	---

Асуудалтай хүүхдүүдтэй ажиллаж байгаа хүмүүс сэтгэл гонсгор байгаагаа үзүүлж болохгүй бөгөөд, энэ нь тэдэнд гологдсон мэт сэтгэгдэл төрүүлэх эсвэл гологдохоос айхад хүргэж болзошгүй тул тэдэнд ийм бодол хэзээ ч төрүүлэхгүй байх нь чухал юм.


Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийн (БМӨХ)онцлог хэрэгцээ

Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг нийгэмд эргүүлэн оруулахад шаардлагатай үйлчилгээнүүд

Дасгалын хуудас **w5.6**

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 26



ба. Биеэ авч явах байдлыг удирдах:

Зорилго:	Бэлгийн хүчирхийлэлд өртсөн эсвэл ашиглагдсан хүүхдүүд тэднийг харж хандаж буй хүмүүст хүндрэл учруулахуйцаар биеэ авч явах нь их байдаг бөгөөд үүний үр дүнд хүүхдүүд ганцаардал, үл тоогдох
-----------------	---

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв
 “Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 27

	байдалтай тулгардаг. Энэ хичээлийн зорилго нь биеэ авч явах байдлыг нь тодорхойлох, ойлгоход нь асран халамжлагчдад туслах, тэдний хүүхэд асран халамжлах чадварыг нь нэмэгдүүлэх, хүүхдийн биеэ авч явах байдлыг нь удирдах ерөнхий стратегийн талаар тэдний мэдлэгийг дээшлүүлэхэд оршино.
Ашиглах материал:	Үзэг, том цаас, дасгалын хуудас wба.1-wба.4. Карт бүрт сэтгэл хөдлөлийн илэрхийлэл нэг нэгийг бичиж бэлдсэн картууд
Хугацаа:	90 – 120 мин

Сургагчийн тэмдэглэл	Сургалтын явц
<ul style="list-style-type: none"> ✓ Асран халамжлагчдаас нь хүүхдүүдийн эдгэх явц нь хамаардаг учраас, тэдний хүүхдүүдэд хандах хандлага, харьцаа нь онцгой чухал гэдгийг онцлох хэрэгтэй. ✓ Хичээл эхлэхээс өмнө картуудыг бэлдсэн байх шаардлагатай. Карт бүр дээр өөр, өөр мэдрэмж байна. Тэдгээрт уур хилэн, түрэмгий зан, хардаж сэрдэх, буруутай байх, үл итгэх, хүчин мөхөс байдал, үнэ цэнэгүй гэх бодол, хайрлагдахгүй байх, дотроо бүгдийг хадгалах, зожигрох, айдас, сэтгэлийн зовнил гэх мэт мэдрэмжүүд орж болно. ✓ Сэтгэл хөдлөлийг үзүүлэхийн тулд яаж илэрхийлэх талаар бодохыг бүлгүүдээс хүс, жишээлбэл, жаргалтай байгааг илэрхийлэхийн тулд “инээсэн” байдал г.м ✓ Биеэ авч яваа байдал нь хүүхдэд ямар ашигтай вэ? Биеэ авч явах энэ байдал нь <u>хэнд</u> хүндрэлтэй вэ? гэдгийг авч үзэх хэрэгтэй. 	<ul style="list-style-type: none"> □ Оролцогчид хэсэг бүлгээр ажиллана (4-6 хүн). Гишүүн бүрт сэтгэл хөдлөлийн карт өг. Оролцогч түүнийг хүүхэд шиг дүрчлэн тоглоно. Бусад нь тэр ямар сэтгэл хөдлөл болохыг таана. □ Хүмүүс энэ дасгалын явцад юу мэдэрснийг нь нийт бүлгээрээ хэлэлц. □ Дасгалын хуудас wба.1-ийг тараан өгч бэлгийн хүчирхийлэлд өртсөн эсвэл бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг хараад юу тохиолдсон байж болох зүйлүүдийг таамаглаж нийт бүлгээр хэлэлц. □ “ “Санааг” “үйлдлээс ” (өөрөөр хэлбэл биеэ авч явах байдлыг) ялгах чадвартай байх нь чухал, учир нь бид үр дүнтэй стратегийг боловсруулахын тулд хүүхэд бидэнд юу хэлэх гэж оролдож байгааг ойлгож чаддаг байх хэрэгтэй” гэдгийг бүлгэд тайлбарла. □ Дасгалын хуудас wба.2-ыг тараан өг. Хоёроос гурван хүнтэй жижиг бүлгээр биеэ авч яваа байдал нь юуг илэрхийлж байгааг авч үз. Нийт бүлгүүдэд танилцуул. □ Дасгалын хуудас wба.3-ыг тарааж өг. Тэдний бодол санаанд ямар нэгэн ялгаа

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 28

<ul style="list-style-type: none"> ✓ Асран халамжлагч болон хүүхдийн хооронд сэтгэл санааны бодит харилцааг тогтоодог учраас биеэ авч явах тал дээрээ онцгой “сайн” анхаараг хэрэгтэй байдаг. Энэ нь бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өрсөний улмаас учирсан нийгэм-сэтгэл зүйн гэмтлийг анагаахад онц их ач холбогдолтой. ✓ Ажлын хуудсан дээр биеэ хэрхэн авч явах, тухайн байдал юу илэрхийлж болохыг хэлсэн тодорхойлолтууд байгаа. Гэхдээ биеэ авч явахба тухайн байдалд тохирох өөр бусад тайлбарууд ч мөн байж болно гэдгийг санаж явах хэрэгтэй. ✓ Биеэ авч явах байдалд аливаа соёл маш их нөлөөлж, тодорхойлдог учир тухайн соёлд “тохирохгүй” санаа байж болох талтай. ✓ Асран халамжлагчдад шаардлагатай олон чадварыг тэд аль хэдий нь эзэмшсэн байсан гэдгийн нь үнэлж байх хэрэгтэй. Тиймээс тэд юу хийж байгаагаа илүү “ойлгон” өөрсдийнхөө чадварыг ашиглах хэрэгтэй гэдгийг ойлгож болох талтай. 	<p>байгаа эсэх талаар бодохыг бүлгээс хүс. Хэрвээ байгаа бол яагаад тэр вэ?</p> <ul style="list-style-type: none"> □ “Биеэ авч явах хэцүү хүнд байдлыг хэрхэн зохицуулах вэ” гэдгийг хэлэлц.Гаргасан санаануудаа том цаасан дээр бич. □ Дасгалын хуудас wба.4-ийг тараан өгөөд биеэ авч явах байдлыг удирдах арга зүйтэй нийт бүлгээрээ танилц.
--	---

Биеэ авч явах байдлыг удирдах

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн \ ашиглагдсан хүүдийг асран халамжлах үед тохиолдож болох биеэ авч явах байдлууд

Дасгалын хуудас **wба.1**

- **Эхний “Бал сарын” үе** (24 цагаас 2-3 долоо хоног үргэлжилж болно)

Хүүхэд хөлөө олж ядан дуулгавартай, талархсан байж болно. Энэ үед тэд биеэ авч явахдаа асуудал гаргахгүй байж болно.

- **Зохицлын үе** (Бал сарын дараах 3-9 долоо хоног)

Урьд нь мэддэг байсан амьдралынхаа “аюулгүй” байдлыг орхисон хүүхэд шинэ нөхцөл байдалд засан зохицох хэрэгтэй болдог. Дасан зохицох энэ явцад хүүхэд шинээр дасан зохицвол зохих зүйлстэй харшилдах дурсамж, мэдрэмжтэй тулгарч болзошгүй.

Хүүхэд:

- Хил хязгаарыг сорьж
- Насанд хүрэгчдийн захиргаадалд дүргүйцэж
- Сахилга батыг зөрчиж
- Уур хилэнгээ илэрхийлж
- Сэтгэл санаагаар унаж
- Эсэргүүцэн босож
- Ердийн амьдрал болон бага цалинг тэнэг зүйл хэмээн бодож
- Хүнсээ нөөцлөх / эд зүйлсээ нуух / өрөө, хаалгаа түгжих / гэрэлтэй унтах / юмаа цүнхлэн явахаар айлгах гэх мэт этгээд зүйлсийг хийж, этгээд үзэл бодол илэрхийлж болох юм.

Энэ үед асран халамжлагчийн хандлага, харьцаа онц чухал ач холбогдолтой.

- **Суурьших үе**

Хүүхэд илүү итгэлтэй болж, биеэ авч явах байдлын асуудлууд аажмаар арилах ёстой. Гэхдээ энэ үе нь хэдэн сар жилээр ч үргэлжилж болзошгүй. Хүүхэд тэдний шинэ ертөнцийг “сорих” явцад хүүхдийн биеэ авч явах зохисгүй байдал эргэж буцаад байх үеүүд гарч болзошгүй.

- **“Нүүх” үе**

Бүрэн “эдгэсний” дараа хүүхэд өөр газар очих хэрэгтэй гэж үзсэн үед хүүхэд залуус дассан газраасаа нүүх үед ямар нэгэн зүйлээ алдсан мэт сэтгэгдэлтэй тэмцэх хэрэгтэй болдог. Энэ нь тэдний сэтгэлийг зовоон тэд илүү эрх мэдэлтэй байж өөрсдийн мэдрэмжийг удирдаж байхыг оролдох учраас биеэ авч явах зохисгүй байдал эргэн ирж болох юм.

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 30

Биеэ авч явах байдлыг удирдах

Та надад юуг мэдэгдэх гэж оролдож байна вэ? Би юу хийж байна, үүгээрээ би юу илэрхийлж байна.....?

Дасгалын хуудас **wба.2**

Биеэ авч явах байдал

Боломжит агуулгууд

Уйлах
Хашгирах
Оргох
Бусдыг дээрэлхэх
Шаардлагыг дагахгүй байх / хэлсэнээр хийхгүй байх
Түрэмгий, ууртай ширүүн
Өөрийнхөөрөө байлгахын тулд дүрсхийн уурлах
Аальгүйтэх
Тамхи татах
Өрөөн дотроосоо цоожлох
Хулгай хийх
Бусадтай өрсөлдөх, барьцах
Аливаа арга хэмжээнд оролцохоос татгалзах
Өөрийгөө гэмтээх (бие эрхтэнээ зүсэх / амиа хорлохыг оролдох г.м)

Биеэ авч явах байдлыг удирдах

Та надад юуг мэдэгдэх гэж оролдож байна вэ? Би юу хийж байна, үүгээрээ би юу илэрхийлж байна.....?

Дасгалын хуудас **wба.3**

Биеэ авч явах байдал

Боломжит агуулгууд

*Уйлах

Надад ямар хэцүү байгааг таныг хараасай гэж би хүсэж байна / Өөрийгөө өөрөө мэдэж, өөрийнхөөрөө хийхийг хүсэж байна / Хэрвээ намайг өрөвдөж байвал миний хүссэнээр хийгээч.

*Хашгирах

Миний хэлснийг сонсохгүй байна / Надад ямар байгааг та нар мэдэхгүй байна / Надад үнэндээ ямар байгааг та мэдчихвэл би илүү эмзэг болох учраас түүнийгээ танд мэдэгдэхийг хүсэхгүй байна.

*Оргох

“Намайг эрээд ололдоо”- Танд би хичнээн чухал болохоо мэдэхийг хүсэж байна / Надад аюултай хэн нэгэнтэй ойр байгаа учраас явах хэрэгтэй байна.

*Бусдыг дээрэлхэх

Би эрх мэдэлтэй, хүч чадалтай гэдгээ мэдрэхийг хүсэж байна / Би ганцаараа муу байдалд байхыг хүсэхгүй байна- Хэн нэгэн надтай адилхан аймаар байдлыг мэдрээсэй гэж би хүсэж байна.

*Шаардлагыг дагахгүй байх / хэлсэнээр хийхгүй байх

Би эрх мэдэлгүй мэт санагдаж байна Тиймээс эрх мэдлээ эргүүлэн авахыг хүсэж байна / Та нар надад үнэхээр сайн эсэхийг чинь мэдэхийг хүсэж байна.

*Түрэмгий, ууртай ширүүн

Би таныг холдуулж болох уу эсвэл та миний талд байна гэж хэлэхдээ үүнийг хэлсэн юм уу? / Би уураа өөрөөр яаж гаргааа мэдэхгүй \ Би мэдэрч

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 32

байна, гэхдээ түүнийгээ ингэж илэрхийлэх нь намайг хамгаалдаг юм.

*Өөрийнхөөрөө байлгахын тулд дүрсхийн уурлах

Надад хэлэх юм, эрх мэдэл алга гэхдээ би эрх мэдэлтэй байж өөрийнхөөрөө байхыг хүсэж байна.

*Аальгүйтэх

Би хүч чадал муутайгаа бага мэдэрч өөрийнхөөрөө байхыг хүсэж байна. Гэхдээ би үүнд хүрэх өөр арга мэдэхгүй.

*Тамхи татах

Би насанд хүрсэн, хэн ч намайг хүмүүжүүлэх хэрэггүй / Би өөртөө санаа зовохгүй байна.

*Өрөөн дотроосоо цоожлох

Хэн ч намайг хамгаалахгүй учраас би өөрөө өөрийгөө хамгаалах хэрэгтэй / Хүмүүс надад муу юм хийж магадгүй учраас тэднээс зай барьж байх хэрэгтэй / Би өөрийн бие даасан байдлаа эргүүлэн олох хэрэгтэй.

*Бусадтай өрсөлдөх, барьцах

Хэрвээ би л өөрийнхөө ашиг сонирхолыг хамгаалахгүй юг бол өөр хэн ч хамгаалахгүй / Би өөрийгөө сайн сайхан гэдгийг мэдэрч байх шаардлагатай бөгөөд бусдаас илүү байна гэдэг бол үүнийг хийх арга мөн / Би амьд явахын төлөө тэмцэж сурсан.

*Аливаа арга хэмжээнд оролцохоос татгалзах

Хүмүүст ойртох нь надад аюултай бөгөөд би тэднээс зай барьж байх ёстой / Би үүнд оролцохоор хангалттай сайн биш.

*Өөрийгөө гэмтээх (бие эрхтэнээ зүсэх / амиа хорлохыг оролдох г.м)

Би их муу байна тэгээд та нарт үүнийгээ яаж мэдүүлэхээ мэдэхгүй байна / Өөрийн сэтгэл санааны хямралыг давахын тулд би өвдөх өвчинд анхаарлаа хандуулах хэрэгтэй.

Эдгээр нь зөвхөн бидний санаа, биеэ авч явах байдал бүрт өөр илүү агуулга байж болно гэдгийг санана уу. Бидний зорилго бол хүүхэд яагаад биеэ ингэж авч яваа

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 33

талаар болон тэднийг ийм байдлаар биеэ авч явахгүй байхад нь туслахын тулд юу хийж болох талаар бодох юм.

Биеэ авч явах байдлыг удирдах

Биеэ сайн авч явахыг урамшуулж, биеэ хүнд хэцүү байдлаар авч явааг удирдах ерөнхий арга зүй.

Дасгалын хуудас **Wба.4**

- **Боломжтой тохиолдол бүрт биеэ муухайгаар авч явааг үл хайхран биеэ сайхнаар авч явахад анхаарлаа төвлөрүүл** – Хүүхдүүд анхаарлыг хүсэж байдаг учраас тэдний хийсэн сайн зүйлүүдэд анхаарч харснаар тэднийг сайн зүйлсийг илүү хийхэд түлхэц болно.
- **Шагналаар дамжуулан биеэ авч явах эерэг байдлыг бэхжүүл** – Энэ нь зөвхөн магтаал байсан ч болно
- **Хүнийг нь биш биеэ авч явах байдлыг шүүмжил** – Жишээ нь, “Чи хүн цохисон муу жаал” биш харин “Хүн цохих гэдэг бол муу юм” г.м. Хүчирхийлэгдсэн хүүхдүүд өөртөө итгэлгүй, өөрийгөө үнэлэх үнэлгээ нь унасан байдаг учраас биеэ авч явах байдлыг эзэмшүүлэх нь тэднийг өөрсдийгөө бусдаас тусгаарлагдсан мэтээр үзэж, үүнээсээ үүдэн ирээдүйд юмыг бусдаас өөрөөр хийж байхаар шийдэхэд хүргэж болзошгүй бөгөөд өөрсдийнхөө талаархи муу бодлоо даван туулахад нь тусалж чаддаггүй.
- **Сурах боломжийг бий болго** – Алдаа бол байж болно гэхдээ тухайн тохиолдлоос үл хамааран цаашид үргэлжлэх та нарын харьцаанд нөлөөлөхгүй гэдгийг хүүхдэд харуул. Жишээ нь, аяганууд авч яваад хагалсан тохиолдолд “Аягаа хагалахгүйн тулд дараа ийм олноор нь битгий авч яваарай” г.м
- **Нэг хэвээрээ бай** – Хүүхэд итгэлтэй байх хэрэгтэй. Үүний нэг хэсэг нь “Дүрэм журмыг” мэдэхээс үүсдэг.
- **Нөхцөл байдал хурцдахаас өмнө анхаарлыг нь сарниул** – Зөрчилдөөнөөс зайлсхийх нь түүнийг арилгахаас амар.
- **Юу хүлээж байгаа болон хэрвээ болохгүй бол юу болох талаар тодорхой бодолтой бай** – Та хүүхдүүдийг юу хийгээсэй гэж хүсэж байгааг тэд мэдэж байгаа гэж бодож болохгүй бөгөөд та тэднийг “Юу” хийгээсэй гэж хүсэж байгаа тухайгаа ойлгомжтой, тодорхой илэрхийлж бай.

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 34

- **Эерэг хэллэг ашигла** – Жишээ нь, “Аягаа битгий тэнд тавь” гэхийн оронд “Аягаа тэнд орхилгүй ширээн дээр тавьчих” г.м. Энэ нь хүүхдийг бүх юм сөрөг биш байдаг харилцаанд оруулан тэдний өөртөө итгэх итгэлийг дээшлүүлнэ.
- **Тэдэнд үгээ хэлэх боломж олгон шударга гэдгээ харуул** – Хүүхдүүд чадал муутай, дээрэлхэгдэж буй мэт санах нь их байдаг тул хүмүүстэй ашиглагдахгүйгээр харилцаж болно гэдгийг тэд олж харах хэрэгтэй байдаг
- **“Сайн” бөгөөд эерэг илгээмжийг өгч бай** – Хүүхдүүдийн сайн, чадварлаг хийж чадаж буй зүйлийг нь тэмдэглэж бай. Үүнийг нь тодотгон хэлж байх нь хүүхдийг өөртөө итгэх итгэлтэй болоход нь туслана
- **Хүүхдэд даалгавар / бусдын сайн сайхны төлөө хариуцлага хүлээхийг нь зөвшөөр** – Энэ хүүхдэд зорилгодоо хүрсний болон хэрэгтэй байхын мэдрэмжийг төрүүлэх бөгөөд өөртөө итгэх итгэлийг нь нэмэгдүүлнэ.
- **Хүүхдийн хяналтын мэдрэмжийг нэмэгдүүл** – Хэдийгээр эцсийн шийдвэрийг тэднээр гаргуулах нь тохирохгүй байж болох ч тэдэнд сонголт олгож, шийдвэр гаргахад оролцуул. Энэ нь тэдэнд өөрсдийнхөө амьдралыг удирдаж байна гэдгийг ухамсарлах ухамсрыг нэмэгдүүлж, чадахгүй, эмзэг гэсэн мэдрэхүйг нь багасгана. Үүнийг хийснээрээ хүүхэд мөн “Аашлахгүйгээр” (жишээлбэл дүрсхийн уурлах г.м) хүссэнээ авахад сурна
- **Санаа бодлыг нь сонсож ойлго** – Та тэдний төлөө санаа тавьж байдаг бөгөөд шударга гэдгийг чинь хүүхдүүд ойлгож үнэлэхэд туслах бөгөөд өөрсдийнхөөрөө хийх эсвэл хэлж буйгаа сонсохын тулд заавал “аашлах” хэрэггүй гэдгийг тэдэнд мэдрүүлнэ
- **Үзэгчид эсвэл хүүхдийг, тухайн үүссэн нөхцөл байдлаас холдуул** – Хэдийгээр тайвшруулахын тулд “завсарлага авах” нь ашигтай байж болох ч энэ аргыг хэрэглэхийн нэг сул тал нь хүүхдийн гадуурхагдсан, ганцаардсан сэтгэгдэл батжихад хүргэж болоход оршдог. Хүүхдийг түлхэж холдуулахаас илүү түүнийг тухайн үүссэн нөхцөл байдлаас холдуулахын зэрэгцээ өөртэйгээ хамт байлгах нь дээр байдаг. Жишээлбэл, зодоон болж байвал та хүүхдийг өөр өрөө рүү ганцааранг нь явуулж болох ч түүнд тантай хамт өөр тийшээ явахыг санал болгох нь дээр байдаг
- **Битгий хэт их залхаан цээрлүүл** – Хэрвээ та хүүхэд байсан бол үүнийг шударга гэж үзэх байсан уу гэж өөрөөсөө асуу (Үнэнч бай)
- **Байдлыг намсгахын тулд хошин шогийн чадвараа ашигла** – Гэхдээ энэ нь хэзээ ч хүүхдээр доог тохуу хийх эсвэл түүнийг доош хийсэн байдлаар байж болохгүй.
- **Уучлал гуй** – Хэрвээ таны буруу бол хийсэн үйлдлээ тайлбарла (Энэ нь тохиромжтой бол). Энэ нь алдаа гаргаж болно гэхдээ түүнээсээ суралцах хэрэгтэй гэдгийг хүүхдүүдэд харуулдаг. Түүний зэрэгцээ мөн итгэл, хүндлэлийг бий болгоход туслана

САНАЖ ЯВ: Асран халамжлагч Та бол Насанд хүрэгч! Тайван бай!

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 35

6b Биеэ авч явах байдлыг удирдах: Биеэ авч явах өдсөн эсвэл хүнд хэцүү байдлыг удирдах (Чадварыг бий болгох)

Зорилго:	Асран халамжлагчид бол хүүхдүүдийн эдгэх явцын чухал хэсгийг бүрдүүлдэг. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн эсвэл бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүд тэднийг харж хандаж буй хүмүүст хүндрэл учруулахуйцаар биеэ авч явах нь их байдаг бөгөөд энэ нь цаашдаа тэднийг ганцаардал, гадуурхалтай тулгарахад хүргэдэг. Энэ хичээлийн зорилго нь асран халамжлагчдад хүүхэдтэй ажиллах ур чадвар болон хүүхдийн биеэ авч явах хүнд хэцүү болон өдсөн байдлыг удирдах чадвараа дээшлүүлэхэд нь туслахад оршино.
Ашиглагдах материал:	Үзэг, том цаас, дасгалын хуудас wба.4 ба wбb.1
Хугацаа:	60-90 минут

<p>Сургагчийн тэмдэглэл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Жишээнүүдэд тэд юу хийх, яг юу гэж хэлэхээ гаргаж өгөх хэрэгтэй. Дасгалын зорилго нь аргуудын талаар зүгээр л нэг мэдэхэд биш тэднийг ашиглах практик дадлагатай болоход байгаа. ✓ Танилцуулах явцад бүлгүүдэд хэцүү санагдсан аргуудын талаар сайтар ярилцах боломж олгон, өөр юу хийж болох талаар саналыг нь асуу. 	<p>Сургалтын явц:</p> <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Дасгалын хуудас wба.4-ийг ашиглан биеэ сайхан авч явахыг урамшуулах арга зүйн талаар нийт бүлгээрээ хэлэлцэн дүгнэ. <input type="checkbox"/> Бичигдсэн арга бүрийг амьдралд хэрэглэх жишээг хэсэг бүлгээр (4-6) гарга. <input type="checkbox"/> Дасгал хэрхэн явагдсан талаар нийт бүлэгтээ танилцуул. <input type="checkbox"/> Дасгалын хуудас wбb.1-ийг тараан өгч “Хэцүү нөхцөл байдлууд” дасгалыг хэсэг бүлгээр хий.
--	---

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 36

<ul style="list-style-type: none"> ✓ Энэ дасгалыг хийхэд их цаг өг. Хэрвээ цаг хязгаартай бол нэг юм уу хоёр жүжигчилсэн тоглолтыг хийж болно (Бүгдийг нь хийж амжихуйц хангалттай цаг байвал). Цаг барихад анхаар! Бүлгүүд өгөгдсөн даалгаврыг хийж байгаа явцыг хяна. ✓ Өгөгдсөн нөхцөл байдлыг удирдах нь бүлгээс хэн нэгэнд санаснаас нь хөнгөн санагдсан уу? Заасан арга зүйнүүд таарч байна гэж тэд бодож байна уу? Өөр ямар нэгэн зүйл хэрэглэх үү? 	<ul style="list-style-type: none"> □ Хүмүүст гайхах ямар нэгэн зүйл байсан эсэхийг тусган нийт бүлэгтээ танилцуул.
--	---

Биеэ авч явах байдлыг удирдах

“Хэцүү нөхцөл байдлууд” – Хэцүү нөхцөл байдлыг удирдах дадлага

Дасгалын хуудас **w6b.1**

- **Удирдамж**

Хэсэг бүлгээр (4-өөс дээш хүн) доор өгөгдсөн сценариар дүрчилсэн тоглолт хий.

Нэг хүнийг асрахын ажилтан, өөр нэгийг хүүхэд/ залуу болж тоглохоор сонго. Бүлгийн үлдсэн гишүүд ажиглагч болох бөгөөд асрахын ажилтанд зөвлөгөө, тусламж үзүүлнэ. (Дүрчилсэн тоглолт бүрт асрахын ажилтанд өөр өөр хүн тоглоно)

Хэрвээ шаардлагатай гэж үзвэл дүрчилсэн тоглолтын явцад асрагч болж байгаа хүн “зогс” командыг өгч тоглолтыг түр зогсоон, тоглолтыг үргэлжлүүлэх илүү сайн арга замыг олохын тулд ажиглагчдын санал, зөвлөгөөг авсны дараа тоглолтыг үргэлжлүүлж болно.

Тоглолт бүрт 15 минут зарцуулна. (10 минут тоглолтод, 5 минут зөвлөлгөө, дүгнэлтэд)

Хүүхдийн дүр: Өгсөн сценаритай зохицуулан дүрийг бүтээнэ. Асрагчийн хэлсэн, хийсэн зүйлүүдээс хүүхдийн хувьд ашиг тустай байж болохоор танд санагдсан зүйлсийг тусгаж ав.

Асрахын ажилтны дүр: Та тухайн өгөгдсөн нөхцөлд хэрхэн ажиллахаа дүрчлэн харуул. Зөвлөлгөө хийх, дүгнэлт гаргах үед тухайн нөхцөлд хийсэн үйлдлээ та яагаад зөв гэж сонгож авсан эсвэл энэ нь дээр гэж шийдсэнээ эргэн хар. Таны үйлдэлд юу нөлөөлсөн бэ? Дараагийн удаа бол та юуг нь өөрөөр хийх вэ? гэдгээ бодож дүгнэн санаа бодлоо бусадтай хуваалц.

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 37

Ажиглагчдын үүрэг: Тоглолтын явцад хэрвээ шаардлагатай бол асрагчид санаа зөвлөгөө өгч тусал. Зөвлөлгөөний явцад асрагч ямар зүйлийг зөв хийсэн гэж үзэж байгаа болон юуг өөрөөр хийж болох байсан гэж бодож байгаа талаараа санал солилц.

- **Дүрчилсэн тоглолтын нөхцөлүүд**

1-р сценари: Хоёр залуугийн хоорон дахь зөрчил

2-р сценари: Ажилтантай сээтгэнэж байгаа өсвөр насны охин

3-р сценари: Амиа хорлохыг хүсэж буй хүүхэд

4-р сценари: Гудамжинд байх нь илүү сайхан гэж үзэн оргох гэж байгаа хүүхэд

7а Эрүүл мэндийн талаар дэмжлэг тусламж үзүүлэх: Эрүүл хэв маягаар амьдрахад нь дэмжиж туслах

Зорилго:	Урьдчилан сэргийлэх, болон нөхөн сэргээхийн аль аль нь онцгой чухал байдаг. Энэ хичээлийн явцад Бэлгийн Мөлжлөгт Өртсөн Хүүхдүүдэд (БТӨХ) тохиолдож болох эрүүл мэндийн асуудлыг ерөнхийд нь үзэхийн зэрэгцээ тэднийг нөхөн сэргээхийн тулд асран халамжлагчид юу хийж болохыг авч үзнэ. Дараачийн бүлгүүдэд тухайн тохиолдол бүрийг илүү тод авч үзэх бөгөөд энэ бүлэгт ерөнхий ойлголтыг л өгөх болно.
Ашиглах материал:	Үзэг, том цаас, дасгалын хуудас w7a.1, w7a2 ба w7a.3
Хугацаа:	60 минут

<p>Сургагчийн тэмдэглэл</p> <ul style="list-style-type: none"> ✓ Энэ бол маш их мэдээлэлийг өгөх урт ажил байх болно. ✓ Сульдаа, тэжээлийн дутагдал, ядаргаа, амьсгалын замын өвчин, ХДХВ болон ДОХ-ын халдвар, БЗХӨ, жирэмслэлт, архи / хар тамхи хэрэглэх, гэмтэл, өмнөх өвчлөлтийн үр дагавар, үүний дээр иммуний дутагдал болон өөр бусад хүүхдийн өвчнүүд байж болно. ✓ Хэрэгцээтэй үйлчилгээнд хувийн ариун цэврийн талаарх сургалт болон хэрэгцээт зүйлсийн хангамж, ердийн өвчнүүдийн эмчилгээ эсвэл эм 	<p>Сургалтын явц</p> <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> БМӨХүүхдүүдэд эрүүл мэндийн ямар асуудлууд тохиолдож болохыг нийт бүлгээрээ хэлэлц. <input type="checkbox"/> “БМӨХүүхдүүд болон Бэлгийн Хүчирхийлэлд Өртсөн Хүүхдүүдэд (БХӨХ) эрүүл мэндийн ямар үйлчилгээ шаардлагатай байж болох талаар болон тэдгээр хүүхдүүдэд хэрхэн хүргэх вэ” гэдгийг хэсэг бүлгээр хэлэлцэж тодорхойл. <input type="checkbox"/> Дасгалын хуудас w7a.1-ийг тарааж өгөөд БМӨХүүхдүүд болон БХӨХүүхдүүдийн эрүүл мэндийн хэрэгцээтэй нийт бүлгээр танилц.
---	---

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 38

<p>хангамж, бэлгийн эрүүл мэндийн боловсрол, зөв хооллох зөвлөгөө болон хүрэлцээтэй хэмжээний хоол хүнсний хангамж зэрэг орж болох бөгөөд үйлчилгээг эрүүл мэндийн төвүүдээр дамжуулан, мөн төвүүд дээр ганцаарчилсан болон бүлгийн сургалт явуулах, зөвлөгөө өгөх явцад хүргэж болох юм.</p> <p>✓ Архи / тамхины хэрэглээ болон ХДХВ / ДОХ-ыг хэрхэх вэ гэдэг талаар асран халамжлагчид санаа зовниж байж болох юм. Эдгээрийн талаар тэдэнтэй ярилц.</p> <p>✓ Асуулт болон хэлэлцүүлэгт хангалттай цаг өг. Завсарлага өгөх эсвэл дасгалын хуудас w7a.3-г хувийн цагаараа уншихаар өгөх нь зүйтэй байж болох юм.</p>	<p>□ “БМӨХүүхдүүдийн асрагчийн хувьд тэдний эрүүл мэндтэй холбоотой ямар асуудлууд бидний санааг зовоож байна вэ?” гэдгийг нийт бүлгээр хэлэлц.</p> <p>□ Дасгалын хуудас w7a.2, w7a.3-тай нийт бүлгээрээ танилц.</p>
--	--

**Эрүүл мэндийн талаархи тусламж дэмжлэг
БМӨХүүхдүүд болон БХӨХүүхдүүдийн эрүүл мэндийн хэрэгцээ
Дасгалын хуудас w7a.1**

Эдгээрт:

- **Хувийн ариун цэвэр**
Зөвлөгөө, тусламж, хэрэгслүүд
- **Хоол тэжээл**
Хоолны дэглэмийн тухай ойлголт болон тохирох хүнсний хангамж
- **Тусгай эмчилгээ үйлчилгээ**
Сүрьеэ г.м өвчин илэрсэн тохиолдолд
- **Архи, тамхи хэрэглэдэг бол мэргэжилтний үйлчилгээ**
Зөвлөгөө өгөх, бүлгээр ажиллах г.м

- **ХДХВ/ДОХ болон БЗХӨ-ний халдвартай тохиолдолд эмчилгээ, халамж, дэмжлэг үзүүлэх**
- **Бэлгийн эрүүл мэндийн боловсрол**
- **Эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ**
Хүүхдийн “ердийн” өвчин болон гэмтлийн үед
- **Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээ**
Дархлаажуулалт, эрүүл мэндийн үзлэг, шүдний эмчилгээ, нүдний үзлэг г.м

Эрүүл мэндийн талаарх тусламж дэмжлэг
ХДХВ болон ДОХ – Вирусын халдвар – Вирус хэрхэн нэг хүнээс нөгөөд халдварладаг вэ?

Дасгалын хуудас **w7a.2**

ХДХВ хүнээс хүнд хэдхэн замаар халддаг:

- Халдвар авсан хүний үрийн шингэн болон умайн шингэнээр дамжин өөр хүний биед дамжин эмэгтэйгээс эрэгтэйд, эрэгтэйгээс эмэгтэйд, эрэгтэйгээс эрэгтэйд, эмэгтэйгээс эмэгтэйд халдварлаж болно.
- Халдвар авсан хүний цус, цусан бүтээгдхүүнээр дамжин халдварлаж болно. Жишээ нь, тарилга хийхдээ тариураа дамжуулан хэрэглэсэн эсвэл шинжилгээ хийгээгүй цус шилжүүлэн юүлэх үед энэхүү халдварыг авч болно
- Жирэмсэн эхээс түүний урагт халдварлана

ХДХВ/ДОХ нь ХДХВ-ээр халдварласан хүмүүстэй ердийн харьцаанд орох явцад халдварладаггүй. ХДХВ-ын халдвартай хүмүүстэй ойрхон байх, тэдэнд хүрэх, тэднийг тэврэхэд аюулгүй.

Эрүүл мэндийн талаархи тусламж дэмжлэг
ХДХВ/ДОХ-ын талаар зарим мэдээлэл

Дасгалын хуудас **w7a.3**

● **ХДХВ / ДОХ гэж юу вэ?**

ДОХ нь хүний дархлал хомсдолын вирус гэж нэрлэгдсэн вирусээр дамжин халдварладаг. ХДХВ нь биеийн дархлаажилтын системийг гэмтээснээр хүнийг бусад өвчнүүдтэй тэмцэх боломжгүй болгодог.

ДОХ бол ХДХВ-ын халдварын сүүлчийн үе шат юм. ХДХВ-ын халдвар ДОХ болон хөгжих хугацаа нь янз бүр байх бөгөөд ихэвчлэн 7 жил байдаг. Тэгэхдээ үүнээс илүү

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 40

урт байх тохиолдол олон байдаг. Эмнэлгийн мэдлэг, эм зүйн хөгжил нь ДОХ-той хүмүүсийг илүү илүү удаан хугацаагаар эрүүл байх боломж олгодог эмүүдийг бий болгожээ.

ХДХВирусын халдвар авсан хүмүүст өвчний ямар нэгэн шинж тэмдэг илрэлгүй олон жил болдог хэдий ч тэд нар энэ үедээ бусдад халдвар тараах боломжтой байдаг.

- **Тэр хэрхэн тархдаг / халдварладаг вэ?**

ХДХВирус нь хүнээс хүнд хэдхэн замаар халдварладаг:

- Халдвар авсан хүний үрийн шингэн болон умайн шингэнээр дамжин өөр хүний биед дамжин эмэгтэйгээс эрэгтэйд, эрэгтэйгээс эмэгтэйд, эрэгтэйгээс эрэгтэйд, эмэгтэйгээс эмэгтэйд халдварладаг.
- Халдвар авсан хүний цус, цусан бүтээгдхүүнээр дамжин, жишээ нь, тарилга хийхдээ тариураа дамжуулан хэрэглэсэн эсвэл шинжилгээ хийгээгүй цус шилжүүлэн юүлэх үед энэхүү халдварыг авч болно
- Жирэмсэн эмэгтэйгээс түүний урагт.

HIV / ДОХ нь HIV вирусээр халдварласан хүмүүстэй ердийн харьцаанд орох явцад халдварладаггүй.

- **ХДХВ ба бэлгийн хавьталт**

Хоёулаа халдваргүй бөгөөд өөр бэлгийн хавьтагчгүй гэдэгт итгэлтэй байгаа хүмүүст ДОХ-ын аюул байдаггүй. Аюултай байж болзошгүй гэж эргэлзэж байгаа тохиолдолд “аюулгүй секс” хийх нь зүйтэй.

Аюулгүй секс гэдэг нь үнсэлцэх, илж таалах болон бэлгийн гүн хавьталд (эр бэлэг эрхтэнг ам, умай эсвэл хошногонд оруулахгүй) орохгүй сексийн өөр бусад хэлбэрийг хэрэглэх эсвэл хэрвээ бэлгийн гүн хавьталд орж байгаа бол бэлгэвч хэрэглэхийг хэлнэ. Гэхдээ халдвар авах аюулаас зайлсхийх ганц арга бол бэлгийн хавьталыг тэвчих юм.

Бэлгэвч хэрэглэсэн ч анальны хавьтал (эр бэлгийн эрхтнийг хошногонд оруулах) нь умайн болон аман хавьталаас хамаагүй их аюултай байдаг.

Бэлэг эрхтний үрэвсэл, шархлаа,идээлэлт болон бусад эмгэгтэй хүмүүс ХДХВирусын халдвар авч бусдад тараах аюул ихтэй байдаг. Иймээс бэлгийн замын аливаа өвчнийг зохих ёсоор эмчлэх нь маш чухал юм.

- **ХДХВ ба цус**

Ариутгаагүй зүү, тариураар тариа хийх нь аюултай. Зүү, тариур нь тариулсан хүнээс цуснаас нь хадгалж үлддэг. Хэрвээ тэр хүний цусанд ХДХВирус байсан бөгөөд хэрэглэсэн зүү, тариураа ариутгалгүйгээр өөр хүнийг тарих юм бол ХДХВирус халдварлана.

Санаандгүй тохиолдлоор халдвар тархаахгүйн тулд нэг удаагийн тариурыг устгаж байх шаардлагатай.

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 41

Халдвар авсан хүний цусыг халдвар аваагүй хүний арьсан дээрх шарх, шархлаанд хүргэхгүй байхад анхаарал тавьж байх шаардлагатай. Энэ нь ХДХВирус хүний цусанд орох замыг нээж өгөх аюултай байдаг.

- **Хэн нэгэн ХДХВ/ДОХ-той болохыг хэрхэн мэдэх вэ**

HIV / ДОХ-ын халдварын “цогц” шинж тэмдэг байдаггүй. Хэдийгээр халдвар авсныхаа дараа зарим нэгэн хүмүүс ханиад маягийн өвчнөөр өвддөг ч халдвар авсан ихэнхи хүмүүс түүнийгээ мэддэггүй.

Нэгэнт дархлалын систем нь гэмтсэн учраас тухайн хүн, биднийг тойрон цаг үргэлж байдаг боловч бидний дархлалын систем ялж сурсан тэдгээр халдварт өвчнүүдэд өртөмтгий болдог. Гэмтсэн дархлалын системийн улмаас өмөн эсвэл хорт хавдар тусаж болох бөгөөд тархи мэдрэлийн систем нь гэмтэж болно. Гэхдээ эдгээр “Шинж тэмдгүүд” нь ХДХВирусын улмаас үүсэхгүй бөгөөд бусад өвчний халдварын илрэл байдаг.

Хүн халдвар авсан эсэхийг мэдэх цорын ганц арга бол ДОХ-ын шинжилгээ авах байдаг.

- **Аюулгүй байх**

Аюулгүй секс хийх, цусаар дамжуулан халдвар авахаас сэргийлснээр ХДХВирусын халдвар авахгүй байж болно.

Хүний мэдлэг хичнээн тэлж, нийгэм хичнээн хөгжиж буй хэдий ч ДОХ-ын тархалтын эсрэг цорын ганц зэвсэг бол нийгмийн боловсрол л байна. Тийм учраас улс орон бүрийн хүн бүр ХДХВирусын халдвар авах, тархаахаас хэрхэн зайлсхийхийг мэддэг байх ёстой.

Өөрсдийгөө хамгаалах, бусдад мэдээлэл түгээн тараах, бусдад туслахад хүүхдүүд чухал үүрэгтэй байдаг. Үүнийг гүйцэтгэхийн тулд тэд вирус хэрхэн халдварлаж, тархдагийг ойлгож мэдэж байх шаардлагатай.

7b Эрүүл мэндийн талаар дэмжлэг тусламж үзүүлэх: ХДХВ ба ДОХ

Зорилго:	Асран халамжлагчид HIV / ДОХ гэж юу болохыг мэдээд зогсохгүй тэр нь хувь хүмүүс болон тэдний ойр дотныхонд хэрхэн нөлөөлдгийг мэдэж ойлгодог байх хэрэгтэй. Энэ бүлэг нь хүүхэд залуустай ажиллахдаа анхаарвал зохих зүйлсийг судлах, улмаар хэрхэн илүү үр дүнтэй ажиллах арга замыг боловсруулахад чиглэсэн болно
Ашиглах материал:	Үзэг, том цаас, дасгалын хуудас w7b.1, w7b.2 ба w7a.3
Хугацаа:	60-90 минут

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 42

Сургагчийн тэмдэглэл	Сургалтын явц
<p>✓ Нийтлэг хариу нь үхэл, айдас, үл тоомсорлох байж болно. Энэ дасгал нь оролцогчдыг хэлэлцэж буй асуудлынхаа талаар бодолд оруулахад чиглэнэ.</p> <p>✓ Дасгалын хуудсуудыг хэлэлцэхэд хангалттай цаг өгнө.</p> <p>✓ Энэ дасгалд их цаг өгч, үүний дүнд үүсэн гарч болох мэдрэмжүүдийг хүлээн авахад бэлэн байна.</p> <p>✓ Хэн үүнийг хийх вэ- Эмч үү? Ажилтан уу? Хэзээ? Яаж? Ямар үр дагавар гарч болох вэ? Амиа хорлох уу? Ялгаварлагдах уу?</p> <p>✓ Хүн бүрийн нэгэн адил ДОХ-той хүүхдүүд ч мөн ХУВИЙН НУУЦтай, БИЕ ДААСАН БАЙХ эрхтэй. Хэн нэгний ДОХ-той эсэх талаар мэдээллийг “Мэдэж байх шаардлагатай” гэсэн үндэслэлд тулгуурлан хуваалцана.</p>	<p><input type="checkbox"/> Дасгалын хуудсуудыг хэлэлцэхэд хангалттай цаг өгнө.</p> <p><input type="checkbox"/> Дасгалын хуудас w7b.1-ийг хүн бүрт бие даан бөглүүлэхээр өг.</p> <p><input type="checkbox"/> Дасгалын хуудас w7b.2-ыг тараан өгөөд хариултуудыг нийт бүлгээрээ хэлэлц.</p> <p><input type="checkbox"/> Дасгалын хуудас w7a.3-ыг нийт бүлгээрээ эргэн хэлэлц.</p> <p><input type="checkbox"/> ДОХ-той нэг хүүхэд, түүнтэй цуг нэг төвд амьдарч байгаа ДОХ-гүй хүүхэд, төвийн ажилтнууд, ДОХ-той хүүхдийн гэр бүл гэсэн 4 багт хуваа. Баг бүр өөрсдийн ногдсон байр суурины үүднээс тэд юу мэдэрч байгаа, юунд санаа зовж байгаа, ДОХ-той гэсэн онош тэдэнд хэрхэн нөлөөлж байгаа талаар авч үзнэ.</p> <p><input type="checkbox"/> Нийт бүлэгтээ танилцуулан хэлэлц.</p> <p><input type="checkbox"/> Хүүхдэд ДОХ-той гэдгийг хэлэхийн далд үр нөлөөг нийт бүлгээрээ авч үз.</p> <p><input type="checkbox"/> “Хүүхэд ДОХ-той гэдгийг хэн мэдэх хэрэгтэй вэ?” гэдгийг нийт бүлгээрээ хэлэлц.</p> <p><input type="checkbox"/> ДОХ-ын халдвартай хүүхэд залууст тавих анхаарал халамжаа сайжруулахын тулд асран халамжлагчид ямар мэдлэг, чадвараа хөгжүүлэх хэрэгтэй болох талаар нийт бүлгээр ярилц.</p>

Эрүүл мэнд – HIV ба ДОХ
ХДХВ/ ДОХ-ын мэдлэгийн талаархи тест
Дасгалын хуудас w7b.1

Үнэн эсвэл Худал гэсэн хариулт өг

Үнэн Худал

- | | |
|---|---|
| 1. ДОХ нь Хүний Дархлал Хомсдолын Вирус буюу товчоор ХДХВ гэж нэрлэгддэг вирусээс үүсдэг. | <input type="checkbox"/> <input type="checkbox"/> |
| 2. ХДХВ-ийн халдвар авсан хүн ДОХ тусаж үхнэ. | <input type="checkbox"/> <input type="checkbox"/> |
| 3. ХДХВ эерэг гэсэн бол тухайн хүн ХДХВ-ийн халдвартай. | <input type="checkbox"/> <input type="checkbox"/> |
| 4. ДОХ нь халдварт өвчин бөгөөд ХДХВ -тай хүмүүс нийгэмд Аюултай | <input type="checkbox"/> <input type="checkbox"/> |

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 43

- | | | |
|--|--------------------------|--------------------------|
| 5. Зөвхөн гей залуучууд ДОХ хүрдэг | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 6. Онгон хүнтэй хурьцал үйлдэх нь и ХДХВирусyг анагаадаг | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 7. Халдвар бүхий хүмүүстэй нийгмийн “ердийн контактад” орсноор ДОХ хүрэхгүй. Тэврэлдэх, гар барих, ханиах, найтаах нь вирусyг тараадаггүй. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 8. Аяга таваг хэрэглэх болон нийтийн жорлонд орохдоо болгоомжтой байх хэрэгтэй, учир нь вирус энэ замаар амархан халддаг. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 9. Хүн хичнээн олон бэлгийн хавьтагчтай байна, халдвар авах аюул төчнөөн их болно. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 10. “Аюулгүй секс” үйлдэх нь ХДХВирусээр халдварлах магадлалыг Багасгадаг. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 11. “Аюулгүй секс” гэж үнсэлцэх, илж таалах, гүн хавьталгүй секс үйлдэх эсвэл бэлгэвч хэрэглэн хурьцахыг хэлнэ. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 12. Хэн нэгэн анх удаа хурьцаж байгаа бол халдвар авдаггүй. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 13. Хар тамхи хэрэглэгчид өөр нэгний “зүйлийг” (зүү г.м) хэрэглэвэл ХДХВирусyн халдвар авах аюултай | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 14. Ариутгаагүй зүү, тариурыг хүүхдийн дархлаажуулалтын программд дахин хэрэглэх нь аюулгүй бөгөөд үүнийг эмнэлгийн мэргэжлийн ажилтан хийх ёстой. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 15. ХДХВирусyн халдвар авсан жирэмсэн эхчүүд төрөөгүй хүүхдээ ХБХВирусээр халдварлуулах аюултай | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 16. Хэрвээ ариутгаагүй багаж зэвсэг хэрэглэн чих цоолох, шүд эмчлэх, шивээс хийх, зүү тавих нь аюултай. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 17. Багаж хэрэгслээ (зүү г.м) давстай бүлээн усаар угааж ариутгаж болно. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 18. Хар тамхи хэрэглэгчтэй хурьцах нь халдвар авах эрсдлийг нэмэгдүүлнэ. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 19. Хүүхдүүдтэй ажиллахад хэрвээ хэн нэгэн хүүхэд ХДХВирусyн халдвартай бол түүнийг хүн бүр мэдэж байх нь чухал. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 20. Хэрвээ хэн нэгэн хүүхэд ХДХВирусyн халдвартай бол төвүүдэд анхан шатны тусламжийн болон ариун цэврийн тусгай арга хэмжээ авах хэрэгтэй. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 21. HIV болон ДОХ-оос болж хүмүүс үхдэггүй. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 22. Хурьцлыг тэвчих нь ДОХ-ын халдвар авахаас зайлсхийх нэг арга | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 23. ХДХВ тестийн сөрөг дүн нь тэр хүн ХДХВирусyн халдвар аваагүй гэсэн үг биш. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| <input type="checkbox"/> 24. ХДХВ тест өгч буй хүмүүс тестийн үр дүнгээс үл хамааран шинжилгээ өгөхийн өмнө болон дараа нь зөвлөгөө авах ёстой | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 25. ХДХВ болон ДОХ-ын талаар ярих нь хүүхэд залуусыг замбараагүй байдалд уруу татаж эсвэл айлгаж болох учраас тэдэнд энэ талаар ярихгүй байх хэрэгтэй. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |

Эрүүл мэнд – HIV ба ДОХ

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 44

Баримт ба цуурхал
Дасгалын хуудас w7b.2

	Үнэн	Худал
1. ДОХ нь Хүний Дархлал Хомсдолын Вирус буюу товчоор ХДХВ гэж нэрлэгддэг вирусээс үүсдэг	*	<input type="checkbox"/>
2. HIV вирусын халдвар авсан хүн ДОХ тусаж үхнэ. ХДХВирусаар халдварласан ихэнхи хүмүүс ДОХ болон үгдэрсэнээр үхэх боловч эмчилгээ сувилал хөгжсөний үр дүнд ХДХВирусын халдвар авсан боловч тэр нь ДОХ бололгүй олон жил болж байгаа хүмүүсийн тоо нэмэгдсээр байна	<input type="checkbox"/>	*
3. ХДХВэрэг гэсэн бол тухайн хүн ХДХВирустай	*	<input type="checkbox"/>
4. ДОХ нь халдварт өвчин бөгөөд ХДХВ-тай хүмүүс нийгэмд Аюултай. Вирус халдварладаг замууд нь тодорхойлогдсон бөгөөд цөөхөн тоотой.	<input type="checkbox"/>	*
5. Зөвхөн гей залууд ДОХ тусдаг.Хэнд ч ХДХВирус халдварлаж болно	<input type="checkbox"/>	*
6. Онгон хүнтэй хурьцал үйлдэх нь ХДХВирусыг анагаадаг. Онгон хүнтэй хурьцал үйлдэх нь ХДХВирусыг анагаахгүй бөгөөд харин онгон хүндээ вирус халдаах аюултай.	<input type="checkbox"/>	*
7. Халдвар бүхий хүмүүстэй нийгмийн “ердийн контактад” орсноор ДОХ тусахгүй. Тэврэлдэх, гар барих, ханиах, найтаах нь вирусыг тараадаггүй. Хэдийгээр ХДХВирусын мөр шүлсэнд олдсон боловч халдвар тараах хэмжээний шүлсний хэмжээ асар их байх шаардлагатай болох тул ийм замаар халдвар авах аюул байхгүй.	*	<input type="checkbox"/>
8 Аяга таваг хэрэглэх болон нийтийн жорлонд орохдоо болгоомжтой байх хэрэгтэй, учир нь вирус энэ замаар амархан халддаг. 7-р асуултын хариулттай адил боловч хэрвээ тухайн хүн бэлэг эрхтнийхээ орчимд үрэвсэл, шархлаатай бол халдвар авах эрсдэл нэмэгддэг тул болгоомжлох арга хэмжээ авах нь зүйтэй.	<input type="checkbox"/>	*
9 Хүн хичнээн олон бэлгийн хавьтагчтай байна, халдвар авах аюул төчнөөн их болно	*	<input type="checkbox"/>
10 “Аюулгүй секс” үйлдэх нь ХДХВирусээр халдварлах магадлалыг Багасгадаг. Ямар ч хавьтал “бүрэн” аюулгүй байдаггүй учраас халдвар авах эрсдэл бага боловч байдаг.	*	<input type="checkbox"/>
11 “Аюулгүй секс” гэж үнсэлцэх, илж таалах, гүн хавьталгүй секс үйлдэх эсвэл бэлгэвч хэрэглэн хурьцахыг хэлнэ.	*	<input type="checkbox"/>
12 Хэн нэгэн анх удаа хурьцаж байгаа бол халдвар авдаггүй.	<input type="checkbox"/>	*
13 Хар тамхи хэрэглэгчид өөр нэгний “зүйлийг” (зүү г.м) хэрэглэвэл ХДХВирусын халдвар авах аюултай. Хар тамхи хэрэглэх үед зүү		

- болон тариурт цус үлддэг бөгөөд энэ нь ХДХВирусyг агуулж байж болно. *
- 14 Ариутгаагүй зүү, тариурыг хүүхдийн дархлаажуулалтын програмдад дахин хэрэглэх нь аюулгүй бөгөөд үүнийг эмнэлгийн мэргэжлийн ажилтан хийх ёстой. Ариутгаагүй ямар ч зүүг дахин хэрэглэж болохгүй. *
- 15 ХДХВирусyн халдвар авсан жирэмсэн эхчүүд төрөөгүй хүүхдээ ХДХВирусээр халдварлуулах аюултай. Гэхдээ халдвар авсан эх болгоны хүүхэд халдвар авсан байдаггүй. *
- 16 Хэрвээ ариутгаагүй багаж зэвсэг хэрэглэж чих цоолох, шүд эмчлэх, шивээс хийх, зүү тавих нь аюултай. Ариутгал хийгээгүй бол хэрэглэж буй багажин дээр нь халдвартай цус үлдэж болно. *
- 17 Багаж хэрэгслээ (зүү г.м) давстай бүлээн усаар угааж ариутгаж болно. Энэ бол ариутгал хийх үр дүнтэй арга биш. Багаж хэрэгслээ тодорхой хугацаанд буцалгах хэрэгтэй бөгөөд эсвэл тусгай химийн бодисуудыг ашиглах хэрэгтэй. Эрсдэлийг багасгахын тулд үргэлж шинэ зүү хэрэглэх хэрэгтэй бөгөөд хуучныгаа хүүхэд, том хүн санааадгүй хүрч болохооргүй газар тавих хэрэгтэй. *
- 18 Хар тамхи хэрэглэгчтэй хурьцал үйлдэх нь халдвар авах эрсдлийг нэмэгдүүлнэ. Хэрвээ хар тамхи хэрэглэдэг бол ХДХВ-н халдвар авах эрсдэл илүү байдаг учраас түүнтэй хурьцал үйлдэх нь мөн халдвар авах эрсдлийг нэмэгдүүлнэ. *
- 19 Хүүхдүүдтэй ажиллахад хэрвээ хэн нэгэн хүүхэд ХДХВирусyн халдвартай бол түүнийг хүн бүр мэдэж байх нь чухал. Энэ бол хувь хүнтэй холбоотой асуудал бөгөөд тэр хүн үүнийг мэдэх ямар шаардлага байна, энэ мэдлэг нь түүнд ямар ач холбогдолтой вэ? *
- 20 Хэрвээ хэн нэгэн хүүхэд ХДХВирусyн халдвартай бол төвүүдэд анхан шатны тусламжийн болон ариун цэврийн тусгай арга хэмжээ авах хэрэгтэй. Энэ бол “зальтай” асуулт. Яагаад гэвэл ХДХВ-н халдвартай хүн ирэхээс өмнө Гепатит г.м бусад өвчин тархахаас сэргийлэн шаардлагатай бүх арга хэмжээг авсан байх учиртай. *
21. ХДХВ болон ДОХ-оос болж хүмүүс үхдэггүй. ХДХВирус нь хүний дархлалын системд нөлөөлж түүнийг гэмтээдэг. Үүний улмаас хүмүүс өөр бусад өвчинтэй тэмцэх чадалгүй болдог. *
22. Хурьцлыг тэвчих нь ДОХ-ын халдвар авахаас зайлсхийх нэг арга. *
23. ХДХВ тестийн сөрөг дүн нь тэр хүн ХДХВирусyн халдвар аваагүй гэсэн үг биш. ХДХВирусанд инкубацийн үе гэж байдаг. Өөрөөр хэлбэл хүн халдвар авсан байсан ч цусанд нь вирус илрэхгүй үе байдаг. Тийм учраас тестийн дүн сөрөг гарсан бол

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 46

3-6 сарын дараа дахин шинжилгээ өгч баталгаажуулах хэрэгтэй.

Энэ хугацааны туршид ямар нэгэн эрсдэлтэй үйлдэл хийхгүй байх нь чухал. Инкубацийн үе нь ихэвчлэн 3 сар

үргэлжилдэг

*

24. ХДХВ тест өгч буй хүмүүс тестийн үр дүнгээс үл хамааран шинжилгээ өгөхийн өмнө болон дараа нь зөвлөгөө авах ёстой. Тэдний амьдралд тэр шинжилгээний үр дүн ямар нөлөө үзүүлэх вэ гэдэг талаар хүмүүс бодож, цаашдын бодлогоо боловсруулах хэрэгтэй байдаг. Үүнд сөрөг дүнтэй гарах ч бас орно. Жишээ нь, нэг гэр бүлд ганцхан хүн халдвар аваагүй бол тэр нь тухайн хүнд яаж нөлөөлөх вэ г.м

*

25. ХДХВ болон ДОХ-ын талаар ярих нь хүүхэд залуусыг замбараагүй байдалд уруу татаж эсвэл айлгаж болох учраас тэдэнд энэ талаар ярихгүй байх хэрэгтэй Хүүхдүүдийг аюулаас сэргийлэхийн тулд тэдэнд мэдээлэл өгч байх хэрэгтэй. Гэхдээ энэ мэдээллийг тэдэнд тохирох бөгөөд ойлгогдох хэлбэрээр өгөх хэрэгтэй

*

7с Эрүүл мэндийн талаар дэмжлэг тусламж үзүүлэх: Мансууруулах бодисын хэрэглээ – Халамжлалаа сайжруулахын тулд мэдлэг ба ойлголтоо нэмэгдүүлэх

Зорилго:	Асран халамжлагчид “ямар нэгэн зүйлд донтох” гэж юу болохыг мэдээд зогсохгүй тэр нь хувь хүмүүс болон тэдний ойр дотныхонд хэрхэн нөлөөлдгийг, энэ нь яагаад хүнд хэцүү нөхцөлд байгаа хүмүүсийн өнгөлөн далдлах арга болдгийг мэдэж ойлгодог байх хэрэгтэй. Энэ бүлэг нь эдгээрийг хэрэглэдэг болсон хүүхэд залуустай ажиллахдаа анхаарвал зохих зүйлсийг судлах, улмаар хэрхэн илүү үр дүнтэй ажиллах арга замыг боловсруулахад чиглэсэн болно
Ашиглах материал:	Үзэг, том цаас, дасгалын хуудас w7c.1, w7c.2, w7c.3(хичээлийг эхлэхийн өмнө дүрийг төлөвлөж бэлд) ба w7c.4
Хугацаа:	60 минут

Сургагчийн тэмдэглэл ✓ Газар зүйн байрлалаас хамааран мансууруулах бодисын хэрэглээ өөр өөр байдаг тул сургагчид нь орон	Сургалтын явц <input type="checkbox"/> “Ямар бодисуудыг буруугаар хэрэглэдэг болон “мансууруулах бодис” гэж үздэг вэ?” гэдэг талаар нийтээр хэлэлцэж ярилц.
--	---

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 47

<p>нутгийн нөхцөл байдалтай танил байх, түүний дотор мансууруулах бодисуудын нийтлэг нэрүүдийг мэддэг байх хэрэгтэй.</p> <p>✓ Оролцогчид олсны ургамал, кокаин, амфетаминууд, героин болон мансууруулах бодис, тайвшруулах нөлөөтэй бодисуудын жагсаалтыг гаргах хэрэгтэй.</p> <p>✓ Хүнд хэцүү дурсамж г.м сэтгэл зүйн эсвэл зүрхний цохилт нэмэгдэх г.м бие хаанд нөлөөлөх нөлөөлөл гарч болно.</p> <p>✓ Хэрвээ бүлэг тань хэтэрхий том бол 8 группэд хуваан категориудаа хоёр хоёр хувь бичин хэрэглэж болно.</p> <p>✓ Энэ дасгалын зорилго нь оролцогчдод зөвлөгөө өгөх чадвар олгох биш харин хүмүүс яагаад эм бодисыг буруу хэрэглэдгийг ойлгоход туслах юм.</p> <p>✓ Оролцогчид өвчин намдаах, амьдралыг илүү сэтгэл хөдлөм болгох, бодит нөхцөл байдлаас ангижрах гэх мэт асуудлуудыг сөхөж болно.</p> <p>✓ Хэрвээ шаардлагатай гэж үзвэл дасгалын хуудас w7c.4-ийг оролцогчиддоо эх сурвалж болгохоор өг.</p>	<p>□ “Мансууруулах бодис болон алкоголь хүмүүст хэрхэн нөлөөлдөг вэ?” нийт бүлгээр хэлэлцэж ярилц.</p> <p>□ “Мансууруулах бодис болон алкоголь хүмүүст хэрхэн нөлөөлдөг вэ?” нийт бүлгээр хэлэлцэж ярилц.</p> <p>□ Нийт бүлгээ 4 группэд хуваа . 4 том цаасан дээр “сэргээш”, “тайвшруулах үйлчилгээтэй эм”, “өвчин намдаагч”, “галлюциноген” гэсэн гарчигуудыг тавиад групп тус бүр оногдсон категорийнхоо эм, бодисны нэрсийг бичнэ. 5-10 минутын дараа нь цааснуудаа хоорондоо солилцон бичнэ. Групп бүр категори бүр дээр өөрсдийн санаагаа гаргатал үргэлжлүүлнэ.</p> <p>□ Хариултуудаа нийт бүлгээрээ хэлэлцээд хэрвээ ямар нэгэн буруу ойлголт байгаа эсэхийг харахын тулд дасгалын хуудас w7c.1-ийг хар.</p> <p>□ Нийт бүлгээрээ ямар нэгэн орхигдсон эм бодис эсвэл тэдний гудамжны нэр байгаа эсэхийг хэлэлцэнэ.</p> <p>□ w7c.2 дасгалын хуудсыг нийт бүлгээрээ үз. Тэгэхдээ энэ бол эм бодисын буруу хэрэглээний талаар үзэхдээ олон газарт хэрэглэдэг эм бодисын хэрэглээний талаархи онолын ажил гэдгийг тайлбарлан хэлж өг.</p> <p>□ Дасгалын хуудас w7c.3 дахь дүрчилсэн тоглолтыг хий. Нэг хүн асрагч, нэг хүн хүүхэд болно. Хосуудын нэгэнд нь “А” хэсэг нөгөөд нь “В” хэсгийг өг.</p> <p>□ Мансууруулах бодис хэрэглэхийг болиулах талаар хэрэглэсэн санаа, баримт нотолгоонууд нь хэр үнэмшилтэй, үр дүнтэй байв гэдэг талаар нийт бүлэгтээ танилцуул.</p> <p>□ “Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдэд эм бодисыг хэрэглэх нь ямар хэрэгтэй вэ, эдгээр хэрэгцээнд нь тустай өөр ямар арга байж болох вэ?” гэдгийг жижиг группээр хэлэлц.</p> <p>□ Нийт бүлэгтээ танилцуул.</p>
---	--

Эрүүл мэнд – Эм бодисын буруу хэрэглээ
Эмийн үндсэн категориуд
 Дасгалын хуудас **w7c.1**

<p style="text-align: center;">Сэргээш</p> <p>Амфетаминууд, кокаин, никотин, кофеин, амил/ бутил нитратууд г.м</p> <ul style="list-style-type: none"> ● Стресстсэн системийг сэргээнэ. ● Сэргэг болгоно. ● Ядаргааг багасгана. ● Хоол идэх дуршлыг багасгана. ● Нойргүйдүүлнэ. ● Сэтгэл санааг сэргээнэ ● Сэтгэл зүйн хараат байдлыг хөгжүүлнэ. ● Бие бялдрын хувьд бол ерөнхийдөө хараат бус 	<p style="text-align: center;">Тайвшруулах эм бодис</p> <p>Алкоголь, тайвшруулагч эмнүүд, GHB – гамма гидрокс бутиратууд, нойрны эмнүүд г.м</p> <ul style="list-style-type: none"> ● Стресстсэн системийг тайвшруулана. ● Айдас түгшүүр, сэтгэл зовнилыг багасгана. ● Бүтээмжийг бууруулна. ● Хүлцэнгүй байдлыг хөгжүүлнэ. ● Хараат байдалд орж болно (биеийн болон сэтгэл санааны) ● Комд оруулж эсвэл үхэлд хүргэж болно. ● Холиход аюултай.
<p style="text-align: center;">Өвчин намсгагчид</p> <p>Опиум, героин, метадон г.м</p> <ul style="list-style-type: none"> ● Өвчин, тохь тухгүй байдлыг мэдрэх мэдрэмжийг багасна. ● Дулаан зөөлөн байдал, сэтгэл ханамжийн мэдрэмжийг төрүүлнэ. ● Таарсан доз хэрэглэсэн үед үйл ажиллагааны бага зэрэг алдагдал байж болно. ● Дозыг давтан хэрэглэвэл хүлцэнгүй байдал болон хараат байдалд (биеийн болон сэтгэл санааны) орно ● Дозыг хэтрүүлбэл үхэлд хүргэж болно 	<p style="text-align: center;">Ой санамжийн функцийг өөрчилдөг эмнүүд буюу галлюцигенүүд</p> <p>Амфетаминууд, кокаин, никотин, кофеин, амил/ бутил нитратууд г.м</p> <ul style="list-style-type: none"> ● Стресстсэн системийг сэргээнэ. ● Сэргэг болгоно. ● Ядралыг багасгана. ● Хоол идэх дуршлыг багасгана. ● Нойргүйдүүлнэ. ● Сэтгэл санааг сэргээнэ. ● Сэтгэл зүйн хараат байдлыг хөгжүүлнэ. ● Бие бялдрын хувьд бол ерөнхийдөө хараат бус.

Галлюциногенний Сэргээшүүд:

Хэт хөөрөл г.м

Ижил шинж тэмдэгтэй сэргээшүүд болон галлюциногенүүд.

Эрүүл мэнд – Эм бодисын буруу хэрэглээ Эм бодисын хэрэглээ ба нөлөөний тухай ойлголт

Дасгалын хуудас **w7c.2**

Энэ бол эм бодисын буруу хэрэглээ болон түүнтэй холбоотой асуудлуудын талаар бодоход ашигтай гэдэг нь нотлогдсон өргөн хэрэглэгддэг онолын ажил юм.

Үр дүнгийн гурвалжин

Бид бодист л гол анхаарлаа хандуулах нь их байдаг, гэтэл энэ бол эмийн үр дүнг тодорхойлдог гурван үндсэн хүчин зүйлийн зөвхөн нэг нь юм.

Хүн

Хэмжээ ба өндөр, тэвчээр, сэтгэл санааны байдал болон
хүлээлт

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 50

- Эм бодис хэрэглэсний
- ҮР ДҮН

Эм бодис

Эм бодисын категори, концентрацийн түвшин, хольц, бусадтай харилцах харилцан үйлчлэл г.м

Хүрээлэн буй орчин

Тойрон хүрээлэгчид, буурь суурьтай байдал г.м

Хэрэглээний гурвалжин

Сэтгэл санаанд нөлөөлөх эм бодисыг хэрэглэх - туршилтын, зугаа цэнгэлийн болон асуудалтай – гэсэн гурван зам байдаг

Туршилтын

Богино хугацаагаар, нэг удаа, шинэ эсвэл хориотой зүйлийг сонирхох үүднээс

- Эм бодисыг
- ХЭРЭГЛЭДЭГ**
- замууд

Зугаа цэнгэл болгон

Хэрэглэх нь урт хугацаанд, тогмол боловч хэрэглээгээ хянаж байдаг

Асуудалтай

Хэрэглээний үед хяналт байхгүй, хэрэглээ нь амин чухал болдог

Ихэнхи хүмүүс сэтгэл санаанд нөлөөлөх ямар нэгэн бодисыг зугаа цэнгэл болгон хэрэглэгчид байдаг боловч үүнийгээ мэддэггүй. Зугаа цэнгээ болгон хэрэглэгчид асуудалтай хэрэглэгч болох нь ховор байдаг.

Хэрэглэгч нэг бодисыг хэрэглэхдээ асуудалтай шатандаа орсон боловч өөр бусад зүйлийг зугаа болгон эсвэл туршин хэрэглэдэг байх тохиолдлууд бий.

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 52

Хэрэглээний гурвалжин

Эрүүл мэнд

Эм бодисын онцлог (юу хэрэглэсэн)
Техникийн онцлог (яаж хэрэглэсэн)
Байрлалын онцлог (хаана хэрэглэсэн)

- Эм бодисын
- хэрэглээнээс
- үүддэг
- АСУУДЛУУД**

Амьдралын хэв маяг

Хууль хяналт, гэр орон, харьцаа
гэр бүлийн асуудал, сургалттай
холбоотой асуудал нь үр нөлөө нь ч
байж болно, шалтгаан нь ч байж болно

Удирдлага

Өрөөл бусдад асуудал учруулах

Эрүүл мэнд – Эм бодисын буруу хэрэглээ
Эм бодисыг буруугаар хэрэглэдэг хүүхэд залуустай ажиллах

Дасгалын хуудас **W7c.3**

Дүрчилсэн тоглолт

Удирдамж:

Нэг нь ажилтан/ асран халамжлагч нөгөө нь эм бодис буруугаар хэрэглэдэг хүүхэд болон хос хосоороо тоглоно.

● **“А” хэсэг: Ажилтан/ асран халамжлагч**

Эм бодисыг буруугаар хэрэглэх нь түүнд сайн зүйл биш гэдгийг хүүхдэд ойлгуулах нь таны үүрэг юм. Түүнд буруутай гэсэн сэтгэгдлийг бүү төрүүл, түүнд утга учир, хор холбогдлыг нь ойлгуулахыг хичээ.

● **“В” хэсэг: Хүүхэд**

Та 15 настай. 14 настайгаасаа биеэ үнэлэх болсон. Таны ээжийг нас барсны дараа, авга ахтайгаа амьдрахаар очсоноос хойш тэр үүнийг хүчээр хийлгэсэн. Тэр “Өөрийгөө өөрөө л тэжээх хэрэгтэй” гэж танд хэлсэн.

Та өөрийгөө аз жаргалгүй, хэн ч таныг хайрладаггүй, ямар үнэ цэнгүй гэж боддог бөгөөд заримдаа амиа хорломоор санагддаг. Найз чинь 6 сарын өмнө таныг героин хэрэглэхэд сургасан. Түүнээс хойш та түүнийг улам бүр их хэрэглэх болсон. Хэрэглэснийхээ дараа та сэтгэл хангалуун, амар тайван бөгөөд онцгой байдлыг мэдэрдэг.

Дүрчилсэн тоглолт дууссаны дараа ногдсон дүрээ бүтээх үед ямар сэтгэгдэл төрсөн талаараа өөр хоорондоо ярилц.

Эрүүл мэнд – Эм бодисын буруу хэрэглээ
Их хэрэглэгддэг зарим эм бодисын талаархи баримтууд

Дасгалын хуудас **W7c.4**

Бодис	Нөлөөлөл	Богино хугацааны хэрэглээ	Урт хугацааны хэрэглээ	Хараат байдал ба зуршил	Анхааруулга
Алкоголь-ууж хэрэглэдэг шингэн бодис	Хэрэглэгч биеэ сул тавьсан, түүний сэтгэл хөдлөл нэмэгдсэн зэргээс болон нийгмийн хорио цээрийн мэдрэмж сулардаг	Хэрэглэснээс хойш 5-10 минутын дотор үйлчилж эхлэн үйлчилгээ нь хэдэн цаг үргэлжилдэг Шингэний алдагдлаас болон толгой өвдөх, бие муудах г.м “шартах” нь ердийн үзэгдэл байдаг	Эрүүл мэндэд хор нөлөө учруулна -элэгний өвчин, зүрхний өвчин, ходоодны шархлаатай болох болон маргамхай болох г.м	Бие болон сэтгэл санааны хараат байдалд орно	Ухаан алдсан үедээ бөөлжсөндөө хахаж үхэх аюултай Бие хаандаа гэмтэл авахуйц үйлдэл хийж болзошгүй

Бодис	Нөлөөлөл	Богино хугацааны хэрэглээ	Урт хугацааны хэрэглээ	Хараат байдал ба зуршил	Анхааруулга
<p>Олсны ургамал – хатаасан өвс, давирхай болон наалдамхай хэлбэртэй байдаг: ихэвчлэн тамхи шиг татаж хэрэглэдэг.</p> <p>Хоол хүнсэнд хольсон байж болно (нөлөөллийг нь урьдчилан хэлэхэд хэцүү)</p>	<p>Хэрэглэгчийн сэтгэл санааны байдал болон хүлээлт, хэрэглэсэн хэмжээ болон байрлалаас хамаарна.</p> <p>Хэрэглэгч амар тайван байдалд орж, өөртөө итгэх итгэл нь нэмэгдэнэ.</p> <p>Туршиж болно</p>	<p>Хэрвээ татах юм бол шууд нөлөөлж болно.</p> <p>Хэрвээ нэг удаад хэт ихийг хэрэглэх юм бол дотор нь муухайрч, бөөлжиж болно.</p> <p>Хэтэртлээ идчихсэн мэт санагдаж, ам хатдаг</p>	<p>Богино хугацаанд ой санамжаа алдах тохиолдол байдаг боловч урт удаан хугацаанд хор нөлөө үзүүлсэн тохиолдол байдаггүй</p>	<p>Хараат байдалд ордоггүй</p>	<p>Дэлхий даяар өвчин намжаахын тулд эмчилгээнд хэрэглэдэг</p>

Бодис	Нөлөөлөл	Богино хугацааны хэрэглээ	Урт хугацааны хэрэглээ	Хараат байдал ба зуршил	Анхааруулга
<p>Кокаин – ихэвчлэн хамраараа сорж хэрэглэдэг цагаан нунтаг.</p> <p>Уусдаг кокаиныг тарьж болно (заримдаа героинтой хольж)</p> <p>Крэк бол татаж болдог илүү цэвэр хэлбэр нь</p>	<p>Сайн сайхан байгаа мэдрэмж, хөгжил баяслыг төрүүлж, хоол идэх дур болон хүч чадлыг бууруулдаг.</p> <p>Нөлөөлөл нь 15-30 минут үргэлжилдэг учраас дахин хэрэглэх хүслийг төрүүлдэг</p>	<p>Дахин давтан хэрэглэх нь сэтгэлийн хэт хөөрөл, түгшүүр, сандрал, уур уцаартай болоход хүргэнэ.</p> <p>Нөлөө нь гарсны дараа ядрал, дотор муухайрал, сэтгэл санааны уналтыг мэдэрнэ</p>	<p>Хэрэглэхээ зогсоосны дараа ч байнгын параноик психозтой болж болно</p> <p>Мансууруулах бодис үнэрлэхтэй холбоотой эрүүл мэндийн асуудал</p>	<p>Сэтгэл санааны хараат байдалд орж болно.</p> <p>Крэк нь бие махбодын хараат байдалд оруулна.</p> <p>Бие махбодь чинь дасахын хэрээр улам ихийг хэрэглэх болдог</p>	<p>Зүрх зогсоход хүргэж болно</p>

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 57

Бодис	Нөлөө-лөл	Богино хугацааны хэрэглээ	Урт хугацааны хэрэглээ	Хараат байдал ба зуршил	Анхааруулга
<p>Экстази – галлюциноген болон амфетаминай ихэвчлэн хольж хэрэглэдэг MDMA.</p> <p>Дээр нь төрлийг нь хэвлэсэн үрлэн эм (таблетка) хэлбэрээр ихэвчлэн байдаг</p>		<p>Хэдийгээр хэрэглэгчид нь илүү эрч хүчийг мэдэрч байвч хөдөлгөөний зохицол алдагддаг.</p> <p>Зүрх болон цусны даралт ихэсдэг.</p> <p>Сэтгэл санааны уналт болон цухалдуу болно</p>	<p>Менст-руацийн хэмнэлд нөлөөлнө.</p> <p>Урт хугацааны хэрэглээ-ний дагавар үр нөлөөний талаар бага мэдэгдсэн</p>	<p>Бие махбодын хараат байдалд орохгүй боловч сэтгэл санааны хараат байдалд орох нь их байдаг.</p> <p>Хурдан дасал болдог боловч татгалзал нь үүнийг багасгана</p>	<p>Үхэлд хүргэж болно</p>
<p>ГНВ/Кетамин Өвчин намдаагч</p> <p>Шингэн хэлбэртэй тайвшруулагч эм, ихэвчлэн залгиж хэрэглэх боловч заримдаа тарьдаг</p>	<p>Хорио цээрийн мэдрэмж буурч, амгалан тайван байдалд оруулна</p>		<p>Ямар нэгэн мэдээлэл байхгүй – энэ эмийг хэрэглэсэн хугацаа нь бага</p>		

Бодис	Нөлөөлөл	Богино хугацааны хэрэглээ	Урт хугацааны хэрэглээ	Хараат байдал ба зуршил	Анхааруулга
<p>Кетамин –</p> <p>Мал эмнэлэгт хэрэглэдэг өвчин намдаагч</p> <p>Үрэл эсвэл нунтаг хэлбэрээр байдаг</p>	<p>Өвчин намдаана</p>	<p>“Хоёрдмол үйлдэл буюу оюун санаа биеэсээ салсан мэт мэдрэмж төрүүлнэ</p>	<p>Мэдэгдээгүй</p>	<p>Зуршил бий болж болох хэдий ч одоогоор энэ талаар мэдээлэл байхгүй</p>	<p>Хэрэглэгчид гэмтэж бэртсэнээ мэдэхгүй байж болно</p>
<p>ЛСД–</p> <p>Ууж хэрэглэдэг синтетик галлюциноген</p>	<p>Бодит байдлаас ангижирна, хий хоосон зүйлс үзэгдэж сонсогдоно</p>	<p>Хэрэглэг-чийн сэтгэл санааны байдал болон хүрээлэн буй орчноос хамаарна.</p> <p>Айдас, түгшүүр дүүрэн аялал” “муу байж болно</p>	<p>Замбараагүй байдалтай болж биеэ мэдрэл муутай мэт авч явах байдалд орж болно</p>	<p>Амархан дасал болдог</p>	<p>ЛСД – ийн нөлөөнд байхдаа осолд орж магадгүй</p>

Бодис	Нөлөөлөл	Богино хугацааны хэрэглээ	Урт хугацааны хэрэглээ	Хараат байдал ба зуршил	Анхааруулга
<p>Хар тамхи-</p> <p>Намуу цэцгээс гаргаж авдаг</p> <p><u>Героин</u> /цэврээрээ/ цагаан нунтаг, усанд уусган тарьдаг.</p> <p>Синтетик хар тамхиууд бас байдаг.</p> <p>Нунтгаа үнэрлэж эсвэл татдаг</p>	<p>Өвчин намдаана.</p> <p>Нервийн системийн ажиллагааг бууруулна, амьсгаадаж, зүрхний цохилт нэмэгдэнэ</p> <p>Тайвшруулна/ өндөр дозоос болж сомд орж болзошгүй</p>	<p>Нойр хүрсэн, дулаан, сэтгэл хангалуун байдал мэдрэгдэнэ</p> <p>Тасалдвал стресс, тухгүйдэлд орно</p>	<p>Гэнэт гарахад бие өвдөнө</p> <p>Амьдарлын хэв маягтай холбоотой (хоол унд муу, ДОХ-той) эрүүл мэндийн асуудал</p> <p>Нийгмийн олон асуудал (ядуурал, гэмт хэрэг) их дагалддаг</p>	<p>Хурдан хугацаанд татагдан ордог</p> <p>Биеийн дасал нь түүнээс гарахыг маш их хүндрүүл-дэг</p> <p>Хурдан дасал болж хэрэглээ нэмэгддэг</p>	<p>Доз хэтрүүлэх аюултай</p> <p>Бусад цэвэр биш бодистой холивол үхлийн коктейль болдог</p>

<p>Тамхи – татдаг, ажилдаг</p>	<p>Сэргээх зөөлөн үйлчилгээтэй</p>	<p>Уур уцаар, стрессийг багасгана</p>	<p>Тамхи татсаны улмаас зүрхний өвчин, хорт хавдар, цус харвалт, амьсгалын зам болон цусны эргэлтгүй холбоотой өвчнүүд үүсдэг</p>	<p>Амархан зуршил болдог тамхинаас гарахад сэтгэл санааны уналт, цухалдуу байдал мэдрэгдэж магадгүй</p>	
<p>Уусгагчид- Үнэрлэвэл алкоголь эсвэл өвчин намдаагчтай адил үйлчилгээ-тэй . цавуу, бензин шатахуун ордог - Пластик уутнаас үнэрлэвэл нөлөөлөл нь нэмэгдэж болно</p>	<p>Уур нь уушигаар дамжин тархинд нөлөөлж сэтгэхүйн гажиг үүсгэдэг</p>	<p>Зүрхний цохилт цөөрч, амьсгал богинос-соноо с болон гүн уушиглавал хяналтаа тэр дороо алдаж болно. Нөлөө нь гарахаар толгой өвдөнө.</p>	<p>Зүрхний мэдрэмтгий чанар нэмэгдсэнээс болон зүрхний ажиллагааны дутагдалд ордог</p>	<p>Зуршил бий болох боловч бие махбодын хараат байдалд орох нь ховор. Сэтгэл санааны хараат байдалд орох нь хааяа байдаг боловч энэ нь ихэвчлэн гэр бүлийн асуудалтай холбоотой байдаг</p>	<p>Үйлчилгээ нь эхэлсэн үед санамсаргүй гэмтэж бэртэх аюултай. Пластик уутандаа боомилог-дон үхэж ч болзошгүй Комд орох болон өөрийнхөө бөөлжсөнд хахах эрсдэл өндөртэй</p>
<p>Тайвшруу-ла х эм болон барбитурат-</p>	<p>Уур цухлыг багасган тайвшруулах үйлчилгээтэй</p>	<p>Бага дозоор хэрэглэвэл хэрэглэгчид чөлөөтэй</p>	<p>Ихээр хэрэглэвэл амьсгалын</p>	<p>Сэтгэл санааны хараат</p>	<p>Гэнэт гарвал үхэлд хүргэж магадгүй.</p>

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 61

Ихэвчлэн үрлэн эм маягаар хэрэглэдэг боловч хааяа тарьдаг	бөгөөд нойр нэмэгдүүлж, хэрэглэгчийг гипноздож болно	тайван мэдрэмж төрүүлнэ. Их доз нь тайвшралд хүргэнэ. Сэтгэл хөдлөл нь тогтворгүй, эсрэг тэсрэг байж болно	асуудал үүсэж болно	байдалд маш хурдан ордог	Санамсар-гүйгэ эр дозоо хэтрүүлэх нь нилээд их байдаг
---	--	--	---------------------	--------------------------	---

8а Нийгэмд болон амьдралд зохицох ур чадвар: Өөртөө итгэх итгэл, бие даасан байдал болон амьдралд шаардлагатай ур чадварыг хөгжүүлэх

Зорилго	Хүүхдүүдэд нийгмийн амьдралын ерөнхий урсгалд эргэн орох болон насанд хүрээд сайн сайхан амьдрахад нь нь туслах чадварыг олгохын тулд тулд өөрсдийн зүгээс ямар ур чадварыг гаргах шаардлагатайг хүмүүжүүлэгчдэд ойлгуулахад энэ хичээлийн зорилго оршино.
Ашиглах материал:	Үзэг, том цаас, дасгалын хуудас w8a.1 – w8a.5
Хугацаа:	60-90 минут

<p>Сургагчийн тэмдэглэл</p> <ul style="list-style-type: none"> ✓ Энэ дасгал нь хэнд ч хэрэггүй амьтан гэж өөрийгөө бодох ямар байдгийг ойлгоход нь оролцогчдод туслана. ✓ Өөрчлөлт нь тогтвортой биш, удаан байдаг бөгөөд заримдаа хэдийгээр дээрдсэн зүйл байгаа боловч аливаа юм улам муудаж байгаа мэт санагдах нь байдаг гэсэн үзэл бодлыг нь батжуул. 	<p>Сургалтын явц</p> <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Оролцогч бүр өөрсдийнхөө талаар бахархаж явдаг гурван зүйлээ бичнэ. <input type="checkbox"/> Тэдгээр зүйлс нь үгүй болчихлоо гэж төсөөлөн бодоод хэрвээ тэгвэл тэд юу мэдэрч, өөрсдийгөө хэрхэн үзэхийг нь асуу. <input type="checkbox"/> БМӨХүүхдүүд өөртөө итгэх итгэл муутай, өөрсдийгөө доогуур үнэлдэг, бусадтай харьцахдаа бэрхшээлд ордог байдаг тэдний өөрсдийгөө төсөөлөх төсөөлөлд нь алсдаа нөлөөлдөг гэдгийг оролцогчдод тайлбарла.
---	--

	<ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Дасгалын хуудас w8a.1-ийг нийт группээрээ үз. <input type="checkbox"/> Бага бүлгээр ажиллан БМӨХ-ийн өөртөө итгэх итгэл болон өөрийгөө үнэлэх үнэлгээг нь нэмэгдүүлэх 6 арга зам болон нийгэмших чадварыг нь дээшлүүлэх 6 арга замын жагсаалт гарга. <input type="checkbox"/> Нийт группдээ танилцуул. <input type="checkbox"/> Нийт бүлгээрээ дасгалын хуудас w8a.2 ба 3-ыг үзэж, группүүдийн гаргасан санаануудтай харьцуул. <input type="checkbox"/> Дасгалын хуудас w8a.4-тэй нийт бүлгээрээ танилц. <input type="checkbox"/> “Хүүхдүүдэд нийгмийн болон амьдралын ямар чадвар хэрэгтэй вэ?” гэдгийг нийт бүлгээрээ хэлэлц. <input type="checkbox"/> Дасгалын хуудас w8a.5-ыг тарааж өг. Тэдний ажиллаж буй программ эдгээр хэрэгцээтэй хэр таарч байгаа болон юуг нь сайжруулах хэрэгтэй байгааг жижиг группээр хэлэлц. <input type="checkbox"/> Нийт бүлэгтээ танилцуул.
--	--

**Амьдрах ба нийгэмших чадвар
Өөрчлөлтийг сурталчлах
Дасгалын хуудас w8a.1**

Өөрчлөлтийн үйл явц




Өөрийн дорой төрх	Тухайн хүүхдийн өөрчлөлт	Өөртөө итгэх итгэл багассан
Бусадтай харьцахад хүндрэлтэй байх / нийгэмших чадвар дорой		Өөрийгөө хүндэтгэх чанар болон өөрийн үнэ цэнээ мэдрэх мэдрэмжээ алдсан

Дээрх өөрчлөлтийг өөрчлөх

Өөрийн эерэг төрх	Тухайн хүүхдийн өөрчлөлт	Өөртөө итгэх итгэл нэмэгдсэн
Бусадтай харьцахад бэрхшээлгүй		Өөрийгөө хүндэтгэх болсон бөгөөд өөрийн үнэ цэнээ мэдэрсэн

Санамж: Өөрчлөлт хэзээ ч тогтмол байдаггүй бөгөөд зурсан шугамаар ч явдаггүй.

Амьдрах ба нийгэмших чадвар
Хүүхдийг өөрийгөө хүндэтгэх чанарт сургах (мөн насанд хүрэгчид)
 Дасгалын хуудас **w8a.2**

 Итгэл	<ul style="list-style-type: none"> ▪ Эерэг зүйлийг өгөх ▪ Хариуцлага / урам өгөх ▪ Магтах ▪ Ололын утга учрыг сурталчлах ▪ Соёлыг сурталчлах ▪ Эерэг үлгэр жишээ үзүүлэх ▪ “Хамаарал”- ын соёлыг түтээх ▪ “Буруутгал” ба сөрөг санааг арилгах / багасгах ▪ Идэвх чармайлт ▪ Ач холбогдолын утга учрыг заах ▪ Өөрийн үзэмжид итгэлтэй байх ▪ Санаа тавьж хайрладагаа харуулах
 Өөрийн үнэ цэнэ	
 Өөрийн ач холбогдол	

Санамж: Өөрийгөө хүндэтгэдэггүй хүүхэд шүүмжлэлд эмзэг байдаг

Амьдрах ба нийгэмших чадвар
Хүүхдийг өөрийгөө хүндэтгэх чанарт сургах (мөн насанд хүрэгчид)
Дасгалын хуудас **w8a.3**

<ul style="list-style-type: none">▪ Тоглоом- хөзөр, бөмбөгөөр тоглох <p style="text-align: center;">БА</p> <ul style="list-style-type: none">▪ Үйл ажиллагаа - Өдөр тутам хийдэг хоол хийх, цэвэрлэх гэх мэтийн гэрийн ажил хийлгэх (үүрэг биш туслах маягаар)▪ Багийн ажил▪ Бие биенээ дэмжих- Хүмүүсээс хүмүүжил, сургамж авах	<ul style="list-style-type: none">▪ Дэвшихэд тус болох зүйлүүд:<ul style="list-style-type: none">○ Бусадтай хуваах чадвар○ Харилцааны чадвар○ Амжилт/уналт ба хожиж/ялагдаж үзсэн○ Идэвх чармайлт○ Тэвчээр○ Өөрийгөө хүндэтгэх▪ Ямар нэгэн асуудлыг шийдэх мөн ямар нэгэн чадвар хөгжүүлэхэд ашиглана, тухайлбал аюулгүй байх, өөрийгөө илэрхийлэх гах зэрэг.▪ Хүүхдүүдэд
--	--

<ul style="list-style-type: none"> ▪ Гадуур хийх үйл ажиллагаа мөн багийн ажил 	<ul style="list-style-type: none"> ▪ Хүүхдүүдэд судлах, нийгэмших чадвартай болох, өөр өөр туршлагатай болоход хэрэгтэй өөр өөр форумоор хангах
---	--

Амьдрах ба нийгэмших чадвар

Эмчилгээ гэж юу вэ?

Дасгалын хуудас **w8a.4**

Хэлэлцэх хоёр гол асуудал.....

- Бүх үйл ажиллагаа мөн нийгмийн үйлчлэл нь өөрийн өсөлт хөгжилд боломж болж энэ нь хүүхдэд эмчилгээ болдог юм.
- Олон эерэг туршлага нь жаргалын далай, сайхан оршихуйг бий болгож энэ нь хүндрэлийг алга болгодог (удаанаар) юм.

Амьдрах ба нийгэмших чадвар

Хүүхдүүдийн эзэмших нийгмийн ба амьдралын чадвар...

Дасгалын хуудас **w8a.5**

- **Эрүүл мэндийн боловсрол-** Тэжээллэг хоол хүнс ба эрүүл ахуй г.м
- **Бэлгийн эрүүл мэндийн боловсрол** - Гэр бүл төлөвлөх
- **Бичиг үсгийн боловсрол**

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 67

- **Тооны мөн эдийн засгийн менежмент- Төсөвлөх**
- **Тусгай мэргэжлийн сургалт/ ажилд ороход боломжийн боловсролтой байх**
- **“Гэрийн эзэгтэйн / эзэн” чадвар**
- **Хүмүүстэй харилцах чадвар- Бусадтай нийлж, аюулгүй харьцаа тогтоож чаддаг байх**
- **“Аюулгүй байх” чадвар- Эрч хүчтэй, өөртөө итгэлтэй байх**
- **Асуудлыг шийдвэрлэх чадвар**
- **Сэтгэл хөдлөлөө зохицуулах ба удирдах чадвар- Уур гэх мэт**
- **Өөрийн үнэ цэнэ, итгэл, зорилгын мэдрэхүй**

8b. Амьдрах ба нийгэмших чадвар: Тусгай чадвар- Биеэ зөв авч явах ба уураа удирдахыг заах

Зорилго:	Энэ хэсэг нь асран хамгаалагчид нь насанд хүрээгүй хүүхдэд өөрийгөө аюулгүй, зөв авч явахад эь туслахад оршино.
Ашиглах материал	Үзэг, том цаас, дасгалын хуудас w8b.1- w8b.4 (энэ хэсгийг эхлэхээс өмнө w8b.3- ийг хасаарай)
Хугацаа:	60-120 минут

Сурагчдын тэмдэглэл:	Сургалтын явц
<ul style="list-style-type: none"> ✓ “Танихгүй хүмүүсээс хол бай.”, “Бусдыг зөвшөөрөлгүйгээр өөрт чинь хүрэхгүй байлгах” зэрэг анхааруулгууд. ✓ Хүчирийлэлд өртсөн хүмүүс ихэвчлэн, хүмүүс хоорондын 	<ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Хосоороо - Хүүхдэд зориулсан анхааруулга бүхий ‘Замын тэмдэг’- ийг тавих <input type="checkbox"/> Анхааруулгын тэмдэгтийг харах. Нийт бүлгээрээ ““аюулгүй байх” гэж юу гэсэн

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв
 “Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 68

<p>харилцан холбооноос айдаг учир өөрсдийгөө эрсдэлтэй байдалд оруулдаг. Энэ нь хүүхдүүд бэлгийн харьцааг, өөрийн авахыг хүссэн зүйлийнхээ төлөө ашиглах магадлалтай гэсэн үг ба маш эрсдэлтэй юм. Энэ дасгал дээр удаан ажилла- хөндөгдсөн асуудлын талаар хүмүүст бодох боломж өгөх хэрэгтэй.</p> <p>✓ ‘Аюулгүй хүрэх’ буюу найз нөхөд, хайртай хүмүүсийн тэврэлтын жишээнүүд, ‘аюултай хүрэх’ буюу ‘нууцаар’ бэлэг эрхтэнд хүрж хүүхдийг таагүй байдалд оруулдаг жишээнүүд.</p> <p>✓ Аюулгүй байхын гол зүйл бол өөрийгөө эрхэмлэн хүндэтгэх (8а хэсгийг хар) мөн бусдын сэтгэл санаа, хүсэл бодлыг хамгаалж чаддагт оршино.</p> <p>✓ Энэ дасгалд багууд өөрийгөө хүндэтгэх ба өөртөө итгэх тал дээр ажиллах хэрэгтэй болно.</p> <p>✓ Эрч хүчтэй, өөртөө итгэлтэй байх нь уураа зохицуулахтай холбоотой бөгөөд энэ нь уураа зохих ёсоор гаргаж, өөртөө сөргөөр нөлөөлүүлэхгүй байх юм.</p>	<p>үг вэ? Хэн аюулгүй байх ёстой вэ? Яагаад?’ гэсэн асуудлаар ярилцах.</p> <p><input type="checkbox"/> Хоёр багт хуваагдаж тайлбарлах-</p> <p>o 1-р баг- Хүүхдүүд аюулгүй байх арга зам</p> <p>o 2-р баг- Томчууд аюулгүй байх арга зам</p> <p><input type="checkbox"/> Нийт бүлэгт танилцуулах</p> <p><input type="checkbox"/> Нийт бүлгээрээ w8b.1-г үзэх</p> <p><input type="checkbox"/> Нийт бүлгээрээ w8b.2-г үзэх</p> <p><input type="checkbox"/> w8b.3- ын тараах материалаас дүрчилсэн тоглолт хосоороо тоглож түрэмгий, идэвхгүй байдалд хариу өгөх.</p> <p><input type="checkbox"/> Дасгалаас нийт бүлэгт танилцуулах</p> <p><input type="checkbox"/> Жижиг бүлэгт хуваагдан аюулгүй байх тухай өөрсдийн санаанд тулгуурласан зөвлөмж гаргах</p> <p><input type="checkbox"/> Зөвлөмжөө нийт бүлэгт танилцуулах</p> <p><input type="checkbox"/> Өөртөө итгэлтэй байх чанарт тулгуурлан уураа барих талаар багт тайлбарлах</p> <p><input type="checkbox"/> Нийт бүлгээрээ ‘Хүмүүс өөрсдийгөө ууртай байна гэдгээ яаж илэрхийлдэг вэ?’ гэсэн сэдвээр санал өрнүүлэх.</p> <p><input type="checkbox"/> Хоёр багт хуваагдан ярилцах</p> <p>o 1-ээр баг- Ажтнууд хэрхэн уурласан хүүхдэд туслаж чадах вэ?</p> <p>o 2-ээр баг- Хүүхдэд зааж, хэрэглэж болох уураа барих аргууд</p> <p><input type="checkbox"/> Нийт бүлгүүдэд танилцуулах</p>
---	--

Амьдрах ба нийгэмших чадвар
Аюулгүй байх- Хүүхдийг хамгаалах арга хэмжээг хөгжүүлэх
Дасгалын хуудас **w8b.1**

● “Хүрэлцэх хүрээ”

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 69

- Зохих зохихгүй хүрэлт, зөв буруу хүрэлтийн ялгааг тайлбарлан судлах
- Дээрх зүйлийг судлахын тулд эрч хүчтэй байдлыг хөгжүүлэх
- “Аюулгүй байдлыг хадгалах” программ
 - Аюултай нөхцөлийг таних
 - “Анхааруулах тэмдгүүдийг” таних – дотоод (айдас, уур хилэн, эвгүй сэтгэгдэл г.м) болон гадаад (үдэш орой ганцаараа алхах, танихгүй хүнээр хүргүүлэх г.м)
 - “Анхааруулах тэмдгүүдийг” мэдэрсэн үед хийх үйлдлүүдийн арг зүйг боловсруулах – Жишээ нь, аюултай нөхцлөөс өөрийгөө авч гарах замууд г.м
 - Аюултай нөхцөл байдлаас зайлсхийх арга замуудыг боловсруулах
 - Өөртөө итгэлтэй зан чанарыг хөгжүүлэх
 - Аюулгүй газар болон хүмүүсийн жагсаалтыг гаргах
- Аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах
 - Аюулгүй байх арга замуудыг мэдэх
 - “Ганцаараа байх боломжтой” газруудыг олж хадгалах (Ванны өрөө, унтлагын өрөө г.м)
 - Өөрийгөө үнэлж хүндэтгэх мэдрэмжийг нь хөгжүүлэх

АЮУЛГҮЙ БАЙХ- Ажилтнуудад зориулав.

- Дасгал сургуулилт
- Хяналт шалгалт
- Хүүхдүүдэд холимог мэдээлэл, мэдрэмж өгч болох нөхцөл байдлуудаас зайлсхийж байх, жишээлбэл, хүрэхдээ болгоомжтой бодолтой байх г.м

Амьдрах ба нийгэмших чадвар

Өөртөө итгэлтэй зан чанар – буюу “Хүссэндээ хэрхэн хүрэх вэ?”...

Дасгалын хуудас **w8b.2**

Идэвхгүй хүмүүс

- Өөрсдийн эрхийг батлаж нотлох талаар ямар нэгэн арга хэмжээ авдаггүй
- Өөрсдийгөө хохироон бусдыг эрхэмлэж үздэг
- Бусдын хүссэнийг нь хийдэг
- Ямар нэгэн зүйл тэднийг зовоож байхад дуугай л байдаг
- Уучлал их гуйдаг

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 70

Эрч хүчтэй хүмүүс

- Өөрсдийн эрхийг бусдын эрх ашгийг хөндөхгүйгээр хамгаалан босдог
- Өөрсдийгөө болон бусдыг хүндэлдэг
- Сонсдог, ярьдаг
- Эерэг болон сөрөг мэдрэмжээ илэрхийлдэг
- Өөртөө итгэлтэй гэхдээ дээрэлхүү биш

Түрэмгий хүмүүс

- Бусдын талаар бодолгүй өөрсдийн эрх ашгийг хамгаалан босдог
- Өөрсдийгөө нэгдүгээрт тавьдаг
- Бусдыг хохироосон ч бай хамаагүй өөрсдийнхөө хүссэнийг авдаг
- Ихэвчлэн бусдад таалагддаггүй

Өөртөө итгэлтэй байх алхамууд

1. Өөрийн мэдрэмж болон асуудлаа тайлбарлаж байх – Жишээлбэл, “Надад ийм ийм зүйл таалагдахгүй байна” гм
2. Хүсэлтээ илэрхийлж байх – Ямар зүйл болоосой гэж хүсэж байгаагаа хэлэх – жишээлбэл, “Би ингэвэл дээр гэж бодож байна”, “Та тэгж болох уу” гм
3. Таны хүсэлт, саналд бусад хүмүүс хэрхэн хандаж байгааг асууж мэдэж байх
4. Тэдний хариултыг сонсоод хариуг нь өгч байх

Хэрвээ нөгөө хүн тань таны бодлыг өөрчлөх хандлагатай зүйл хэлэх юм уу таныг ятгахыг оролдвол тэднийг зогсоогоод “Би ... гэж хэлсэн” гэх мэтээр эргэн өөрийнхөө хэлсэн рүү орох эсвэл “Би энэ талаар дахин бодоод тань руу эргэж мэдэгдье” гэх мэтээр цаг авахыг бод.

Амьдрах ба нийгэмших чадвар

Өөртөө итгэлтэй байх дасгал

Дасгалын хуудас **w8b.3**

Бүх дүрчилсэн тоглолтууд хосоор хийгдэх бөгөөд дүрүүдийг нэгнээсээ нуу. Идэвхгүй, түрэмгий болон өөртөө итгэлтэй хариултуудыг ээлжлэн өг.

- **Дүрийн тоглолт №1**

Залуу хүн –

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 71

Үдэш орой болжээ... Та найз нарындаа зочилж байгаад автобуснаасаа хоцорсон байна. Та оройтсон бөгөөд гэртээ очоод загнуулна гэдгээ мэдэж байна.

Эр –

Үдэш орой болжээ... Залуу хүнд машинаараа хүргэж өгөх санал тавь, гэхдээ татгалзвал нь зүгээр л хүлээж ав.

- **Дүрийн тоглолт №2**

1-р залуу хүн

Та хоёр удаан хугацаанд найзалсан бөгөөд сар орчим болзож байгаа... Та хурьцахыг хүсэж байгаа бөгөөд өнөө орой танд найзыгаа (2-р залуу хүн) ятгах боломж олдохуйц үдэшлэг болно ... Амжилт олохыг хичээ.

2-р залуу хүн

Та хоёр удаан хугацаанд найзалсан бөгөөд сар орчим болзож байгаа... Та таны найз тантай хурьцал хийхийг хүсэж байгааг та мэдэж байгаа боловч цаг болсон гэж та бодохгүй байна.

- **Дүрийн тоглолт №3**

1-р залуу хүн

Хурьцал үйлдсэний тань төлөө танд мөнгө өгдөг “найз” танд байдаг. Энэ бол амархан мөнгө гэж та боддог. Түүний бизнесийн түнш нь танай хотод ирж байгаа бөгөөд хэрвээ та түүнийг “зугаацуулах” найз олж чадвал танд их мөнгө өгнө гэж тэр танд хэлжээ. Найзыгаа өөртэйгээ цуг явахыг аль чадахаараа ятга – “үгүй” гэсэн хариултыг бүү хүлээж ав.

2-р залуу хүн

Та өөрийгөө хэрхэн аюулгүй авч явахаа мэддэг боловч хотод дөнгөж орж ирээд байгаа. Одоогоор танд ямар ч найз байхгүй байна....

Амьдрах ба нийгэмших чадвар
Уурласан хүүхдийг удирдах менежмент
Дасгалын хуудас **w8b.4**

Хүүхдүүд уурласан үед насанд хүрэгчид дараахь зүйлсийг хийж болох юм.

- **Уурлаж байх үед нь:**

- Тайван байх

Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв

“Бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг сэтгэлзүйн хувьд нөхөн сэргээх нь” сургагчдад зориулсан гарын авлага.[Type text] 72

- Хоолойгоо намдуу, нэг хэвийн байлгах
- Уурыг нь хүргэсэн зүйлийг ойлгохыг хичээх
- Хүүхдийн хэлж байгаа зүйлийг сонсож, үүнийгээ харуулах
- Бусдаас тусгаарлах (“хөндлөнгийн” хүмүүс болон тухайн зөрчилд оролцогчдыг холдуул)

■ **Уурласных нь дараа эсвэл уурлахынх нь өмнө**

- Уур хилэн болон түрэмгий энергээ гаргах боломж олгох (ж нь,спорт)
- Сэтгэл хөдлөлийн энергийг судалж, гаргах боломжоор хангах – ярилцах, эмчилгээ хийх болон харьцахад хэзээд бэлэн байх гэх мэтээр
- “Өөртэйгөө ярихад” сургах – “тайван бай”, “битгий уурла” гм хэрэгтэй зүйлсийг өөртөө хэлэх
- “Өөрийгөө тайвшруулах техникийг” заах – амьсгалаа тоолох / хянах, холдож явах гм
- “Өөрийгөө тайвшруулах техникийг” медитаци, биеэ суллах, өөртөө итгэлтэй байх гм төслийн бусад зохих программуудтай хамтатгах
- Боломжтой газруудад орчинг нь сайжруулах – жишээлбэл, “тайван өнгө”, тайвшруулахуйц хөгжим, үнэрийн терапи гм.